МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn,
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2023.05.11. № 03/1057

танай ____________-ны №____________-т

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРК УЛСЫН ТӨСӨВТ
ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ
Ж.ЗОЛЗАЯА ТАНАА

Хяналт шалгалтын ажлын дүгнэлт
зөвлөмж хүргүүлэх тухай

"Мэдээлэл, технологийн үндэсний парк" УТҮГ-ын 2022 оны үйл ажиллагааны тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт, зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна. Зөвлөмжийн биелэлтийг ханган ажиллана уу.

Хавсралт ..... хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ

1523083320

# “МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРК” УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН БАЙДЛААР ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН

2023.05.01 № Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь “Мэдээлэл технологийн үндэсний парк” УТҮГ-ын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 109 арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцыг урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт-шинжилгээ хийж, байгууллагын үйл ажиллагаа, бодлогын баримт бичгийн зорилго, зорилтын хэрэгжилтийг төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн эсэхийг үнэлж, үр дүнг нь дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2022 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй"-д тулгуурлах зарчмыг баримталлаа.

## ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан нийт 109 арга хэмжээний 2022 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа:

1. Бүрэн хэрэгжсэн үр дүнтэй буюу 100%-ийн гүйцэтгэлтэй – 31 арга хэмжээ;
2. Холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч ирж байгаа, тодорхой үр дүнд хүрсэн буюу 90%-ийн гүйцэтгэлтэй -17 арга хэмжээ;
3. Дээд шатны байгууллагад өргөн барьсан, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70%-ийн гүйцэтгэлтэй – 18 арга хэмжээ;
4. Боловсруулалтын шатны арга хэмжээ хийгдсэн буюу 50%-ийн гүйцэтгэлтэй – 17 арга хэмжээ;
5. Эрчимжүүлэх шаардлагатай шатанд байгаа буюу 30% гүйцэтгэлтэй- 16 арга хэмжээ;
6. Үр дүнгүй буюу 0%-ийн гүйцэтгэлтэй– 10 арга хэмжээ байна.

Дээр дурдсан арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг арифметик дунджаар тооцож үзэхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 66.24 хувьтай үнэлэгдсэн болно.

## ГУРАВ.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзэхэд бүрэн хэрэгжсэн, тодорхой шийдвэрүүд гарч үр дүн гарч байгаа, тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ нийт арга хэмжээний дийлэнх хувийг эзэлж байна. Тухайлбал Өсвөрийн зохион бүтээгчдийн сургалтыг зохион байгуулах төлөвлөгөөний биелэлтийг “Нисгэгч хүүхдүүд сургалтыг 2 удаа

зохион байгуулж 40, "Сансарт илгээх ил захидал" арга хэмжээг 9 удаа зохион байгуулж 533, "Зугаатай шинжлэх ухаан" сургалтыг 4 удаа зохион байгуулж 31, "Кодинг+Инженерчлэл" багц хөтөлбөрийн сургалтыг 8 удаа зохион байгуулж нийт 130, "Өсвөрийн сансрын инженер" анхан шатны сургалтыг 5 удаа зохион байгуулж 47, "Science EQ" анхан шатны сургалтыг 4 удаа зохион байгуулж 36 нийт 6 төрлийн арга хэмжээг 32 удаа зохион байгуулж 817 хүүхэд хамрагдсан байна" гэжээ. Өөрөөр хэлбэл дээрх арга хэмжээг төлөвлөснөөс давуулан биелүүлсэн гэж үзэхээр байна.

Мөн Сүлжээ, холбооны тоног төхөөрөмжийн найдвартай хэвийн ажиллагааг хангах төлөвлөгөөний биелэлтийг "МТҮП-н байранд интернэт сүлжээ удаа дараалан тасалдсаныг цаг тухайд нь засварласан. 7 өрөөнд шинэ порт нэмж сүлжээ орууллаа. "Монголын Инновацийн 7 хоног" арга хэмжээ МТҮПаркад зохион байгуулагдах болсонтой холбогдуулан 05.16-25 ны өдрүүдэд Мобинэт ХХК-ийн утасгүй интернэтийг хязгааргүй хурдтайгаар нэвтрүүлж интернэтээр хангаж ажилласан. "Ситинет" ХХК-тай гэрээг цуцалж, Мобинеттэй гэрээ байгуулан холболтын ажлыг мобикомын инженертэй хамтран гүйцэтгэсэн. Ситинетийн эзэмшлийн 3ш свичийг хүлээлгэн өгч, 211-ийн 2 свич, Оффисын свич, 4-р давхрын свичүүдийг шинэчлэн ажиллаа. Серверийн өрөөний файл серверийг засварлан дотоод сүлжээнд ашиглаж байна. 2023 онд үүлэн технологийг ашиглан шийдэхээр төлөвлөөд байна. Сургалт, шалгалт, танхим түрээс бусад үйл ажиллагаануудад сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллав. Байгууллагын дотуур холбооны 2 телефон утсыг засаж ашиглалтад оруулсан. Мөн мэдээлэл хандалтын төвд сүлжээ оруулав. Мөн техникийн тусламж дэмжлэг үзүүллээ" гэж тайлагнасан байна.

Харин хэрэгжилт хангалтгүй, үр дүнг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй буюу гүйцэтгэлгүй арга хэмжээ нийт арга хэмжээний 25 орчим хувийг эзэлж байна. Санхүүжилт удаашралтай байгаагаас шалтгаалан хэрэгжилт хангалтгүй буюу үр дүнгүй үнэлэгдсэн зарим арга эрчимжүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төлөвлөлт буруу буюу хэт ерөнхий, үр дүнд хүрэхээр төлөвлөөгүй, үйл ажиллагааны зохион байгуулалт хангалтгүй зэргээс шалтгаалан хангалтгүй буюу 30 хувиар үнэлэгдэж байгаа дараах арга хэмжээнүүд байгааг жишээ байдлаар дурдвал:

- "Инкубаторын цогц үйлчилгээ үзүүлэх, /Инноваци, оюуны өмч, хууль эрх зүй бусад сургалт, хэрэглэгчдийн уулзалт зохион байгуулах бусад/"
- Үндсэн болон захиалгат сургалтыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд "Шалгалтанд бэлтгэх сургалт зохион байгуулж 20-оос дээш суралцагч хамруулан тэнцэгчдийн чанарыг 5 хувиар нэмэгдүүлсэн байна" гэх үр дүндээ хүрээгүй.
- "Үйл ажиллагааны инноваци" гэж төлөвлөгөөнд тусгаж суурь түвшин, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтгүй байгаа нь ямар үр дүнд хүрэхээр төлөвлөж байгаа тодорхойгүй.

Тус газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний нийт 109 арга хэмжээний хувьд зорилтыг ойлгомжтой, тодорхой агуулгаар тусгасан ч арга хэмжээ бүрийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг зорилттой уялдуулан тусгаагүйгээс зорилт болон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин хооронд зөрүүтэй байдал үүсэх, хэрэгжүүлэх арга замыг ойлгомжгүй тодорхойлоогүй, арга хэмжээний биелэлтийг зорилт, шалгуур үзүүлэлттэй нийцэлгүй байдлаар тайлагнах зэрэг нийтлэг алдаа дутагдлаас үүдэн үнэлгээ хийхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэж байна.

## ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Хэрэгжилт хангалтгүй ажлуудыг 2023 онд эрчимжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаар батлуулахаас өмнө Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалд заасан аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтийг үр дүнд хүрсэн байдлаар бэлтгэх буюу тоо, чанарын утгаар илэрхийлэх;

2. Засгийн газрын урт, дунд богино хугацааны бодлогын баримт бичиг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын стратеги төлөвлөгөө болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг холбогдох хууль, журам бодлогын баримт бичгүүдэд заасан хугацаанаас өмнө биелэлтийг хүргүүлж хэвших;

3. Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, нотлох баримтад тулгуурласан байдлаар гаргаж хэвших;

4. Үр дүнд суурилсан бодит нотолгоонд тулгуурласан тайлан бичиж ирүүлэх;

5. Тайланг 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, товчилсон үг хэллэг ашиглахгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, цэгцтэй эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

6. Төлөвлөгөөний зорилт, шалгуур үзүүлэлтийн дагуу бичсэн хэрэгжилтийг нягтлан уншиж, нотлох баримтын хамтаар яамны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжид өгч хэвших;

7. Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-оОо-

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# МЭДЭЭЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ПАРКЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний тоон контент, программ хангамжийн үйлдвэрлэлийг дэмжих** | | | | | | | |
| **Зорилт 1.1** Мэдээллийн технологийн гарааны бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх | | | | | | | |
| 1.1.1 | Инкубаторын үйл ажиллагааг сайжруулах | - | Элсэлт, төгсөлтийн тоо | Элсэлт-2 Төгсөлт 2 | Сонгон шалгаруулалтад оролцогчдын тоог 50%-иар (2020 онд сонгон шалгаруулалтад оролцогчдын тоо- 18), ОӨ-өөр баталгаажсан хөрөнгөтэй төгсөгч компанийн тоог 3%-иар тус тус нэмэгдүүлсэн байна. | 1. Элсэгчдэд зориулсан семинарыг 7 удаа зохион байгуулж 45 оролцогч хамруулсан бөгөөд 2021 оны оролцогчдоос 88% нэмэгдүүлэв.<br>2. Инкубаторын элсэлтийг 4 удаа /зорилтот салбар-1, ахисан түвшин-1, үндсэн инкубатор-2 удаа/ зохион байгуулж, 37 оролцогч хамрагдсанаас 13 компани /виртуал инкубатор-2, үндсэн-11/ тэнцэж, одоогийн байдлаар нийт 21 компанид /үндсэн инкубатор-16, Ахисан түвшин-3, виртуал-2/ үйлчилгээ үзүүлж байна.<br>3. 2022 онд оюуны өмч, барааны тэмдэг авсан инкубаторын 12 компанид, 2023 онд авахаар төлөвлөж буй 4 нийт 16 компанид зөвлөгөө үйлчилгээ үзүүлж ажиллав. Өмнөх онтой харьцуулахад 33% нэмэгдүүлсэн.<br>4. Төгсөлтийн үнэлгээнд нийт 9 компани хамрагдсан бөгөөд хугацаанаас өмнө төгссөн-1, хасагдсан-2, шилдэг төгсөгч-1, ахисан түвшин-1, амжилттай төгсөгч-4 байна. Төгсөлтийн дундаж үнэлгээ 89% | 100 |
| | | | Судалгаа, хамтын ажиллагаа | - | Компаниудын ОӨ-ийн үнэлгээг гаргах тогтолцоо бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн байна. | 1. Оюуны өмчийн судалгаанд инкубаторын 12 компани хамрагдсан бөгөөд судалгаанд хамрагдсан компаниудын 50% нь оюуны өмчийн эрхийн хамгаалалт хийлгэсэн, 17% нь эдийн засгийн үнэлгээ хийлгэсэн байна. Уг судалгааны үр дүнд үндэслэн компаниудын оюуны өмчийн бүтээл, цаашид эрхийн хамгаалалт хийлгэх, үнэлгээ хийлгэх бүтээлийн жагсаалтыг тус тус гаргав.<br>2. "Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт"-тай судалгаа хийж бааз бүрдүүлэх, оюуны өмчийн эрхийн хамгаалалт, үнэлгээ, компанийн үнэлгээ хийх тогтолцоог бүрдүүлэх зэрэг чиглэлээр хамтран ажиллах гэрээг 2022.09.06-нд байгуулж, хамтран ажиллах төлөвлөгөөг батлав. | 100 |
| 1.1.2 | хагас жил, сар тутмын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж үнэлгээ өгөх | - | Инкубаторын компаний тоо | - | Хагас жилийн үнэлгээ 5 удаа, сар тутмын үнэлгээг 12 удаа зохион байгуулсан байна. | Хагас жилийн үнэлгээг 5 удаа зохион байгуулж үүнээс Төгсөлт-3 удаа, хагас жилийн үнэлгээг-2 удаа зохион байгуулав.Үнэлгээнд орсон компаниудын дундаж 81.7% байна. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сарын үнэлгээг нийт 12 удаа зохион байгуулсан бөгөөд компаниудын дундаж үнэлгээ 91%, үйл ажиллагааны үзүүлэлтийн дундаж 95%, эдийн засгийн үзүүлэлт-84%, үүрэг хариуцлагын үзүүлэлт-93% байна. | |
| 1.1.3 | Инкубаторын цогц үйлчилгээ үзүүлэх, /Инноваци, оюуны өмч, хууль эрх зүй бусад сургалт, хэрэглэгчдийн уулзалт зохион байгуулах бусад/ | - | Үйлчилгээний тоо | - | Хэрэглэгчдийн уулзалт 4 удаа, захирлын уулзалт 12 удаа, цогц үйлчилгээ компани тус бүрт хүргэн чиглэл бүрээр нийт 6 удаа сургалт, арга хэмжээ зохион байгуулсан байна. | 1. Хэрэглэгчдийн уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд "Инновацын 7 хоног", "Start now", Мягмар гарагийн уулзалт, Монгол-Япон бизнес түншлэл, It business innovation days үзэсгэлэн, Шинэ сэргэлтийн бодлого, Аспа арга хэмжээ, Инновац хөгжүүлэх боломж шийдэл үзэсгэлэн, BNI 9 удаагийн арга хэмжээ дээр компаниудын оролцоог хангаж ажиллав. Нийт 350 орчим оролцогчид хамрагдаж хамтын ажиллагаа өрнүүлэв.<br>2. Захирлуудын уулзалтыг 12 удаа зохион байгуулсан бөгөөд 3 удаагийн уулзалтыг VIP байдлаар зохион байгуулж давхардсан тоогоор нийт 17 оролцогч хамрагдав. Компаниудын идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор нэрэмжит сар үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд 6 компани оролцон бусад компаниудтай хамтын ажиллагаа өрнүүлж, мэдээ мэдээлэл солилцов.<br>3. Инкубатор компаниудад зориулсан сургалт арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд 14 компаниас судалгаа авсан бөгөөд судалгааны үр дүнд тулгуурлан сургалт арга хэмжээний календарчилсан төлөвлөгөө гаргав. 2022 онд ут төлөвлөгөөний дагуу нийт 8 удаагийн сургалт, 23 төрлийн арга хэмжээ зохион байгуулж давхардсан тоогоор инкубаторын 125 оролцогч хамрагдсан байна.<br>4. "Таван Богд Капитал" ҮЦК-тай хамтран хөрөнгө оруулалтын ерөнхий мэдээлэл, IPO, хувьцаа, бонд, үнэт цаасны хөрөнгө оруулалтын тухай сургалтыг 2022.11.30-нд зохион байгуулав. Цаашид "Таван Богд Капитал" ҮЦК-тай хамтран МТҮП-ын инкубаторын компаниудыг хөрөнгө оруулагчидтай зуучлах, хөрөнгө босгох, IPO-н талаар хамтран ажиллахаар болов. | 70 |
| | | | Сургалтын тоо | - | Гарааны компаниудад оюуны өмч, бизнесийн удирдлага, төслийн удирдлагын чиглэлээр 4 удаа сургалт зохион байгуулсан байна. | Оюуны өмчийн зөвлөх үйлчилгээ: Инкубаторын 7 компанийн барааны тэмдэгт, 1 компанийн программ хангамжийг зохиогчийн эрхээр бүртгүүлэхээр Оюуны өмчийн газарт мэдүүлэг гаргасан. | 0 |
| **Технологи дамжуулах үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |
| **Зорилт 2.1** Инновацийг дэмжихэд оролцогч талуудын хамтын ажиллагааг идэвхижүүлэх | | | | | | | |
| 2.1.1 | Технологид суурилсан бүтээлч сэтгэлгээг дэмжих, арга хэмжээ зохион байгуулах, төвлөрлийг бий болгох | 1- | Шилдэг санааны тоо | - | 4 удаагийн Питч зохион байгуулж, шилдэг санааг шалгаруулан 2-3 баг, иргэнд дэмжлэг үзүүлсэн байна. | 1. Мэдээлэл зүйн 36-р олимпиадын бүтээлийн уралдааныг 5-р сарын 2-нд зохион байгуулж, "Space academy"-н сургалт болон "Чимэгэ системс" програмыг ашиглах эрхийн бичгээр тус тус шагнав. Уралдаанд нийт 3 багийн 4 оролцогч оролцсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. "Инновацийн боломж, шийдэл 2022" арга хэмжээг Нийслэлийн ЖДҮҮ дэмжих төвтэй хамтран хамтран зохион байгуулав. Уг арга хэмжээнд инкубаторын төгсөгч компани болох "Юникүе повер теч" ХХК нь өөрсдийн төслийг хэлэлцүүлж, шийдлийн талбараас дэмжлэг авсан бол "СИМ ХХК" нь ухаалаг худаг, автобусны картны төслөө танилцуулав.<br>3. Төрийн өмчит их дээд сургуулиудын оюутнуудын дунд зохион байгуулагдсан "Гавал толгой" тэмцээнийг ХААИС-ийн эдийн засаг, инновацийн хөгжлийн төвтэй хамтран 5 сарын 17-нд зохион байгуулж шилдэг 3 багийг шалгаруулав. Шагналт байранд орсон 3 багт Виртуал инкубаторт элсэх эрхийн бичиг, 3 сургалтын эрхийн бичгээр тус тус шагнав.<br>4. ШУА-тай хамтран 5-р сарын 17, 19-ний өдрүүдэд "Эрдэм хакатон"-ыг зохион байгуулж, МТҮП-ын тусгай шагнал болох инкубаторт элсэх эрхийн бичгийг ТОБИ багт гардуулав.<br>5. Founder Institute Mongolia-тай хамтран "pre-seed" хурдасгуур хөтөлбөрийг 03.21-ээс 06.28-ны хооронд зохион байгуулав.<br>НИЙТ 5 УДААГИЙН ПИТЧ, ХАКАТОН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЖ ИНКУБАТОРТ ЭЛСЭХ ЭРХИЙН БИЧГИЙГ 4 БАГТ, СУРГАЛТЫН ТӨВИЙН ЭРХИЙН БИЧГИЙГ 2 БАГТ ТУС ТУС ГАРДУУЛЖ ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭВ. | |
| | | - | Гэрээний тоо | - | 2. Гарааны бизнесийг дэмжих чиглэлээр 3-4 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулсан байна. | 1. Гарааны компаниудад зориулсан "pre-seed" хурдасгуур хөтөлбөрийг хамтран зохион байгуулахаар Founder Institute Mongolia-тай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулав.<br>2. Шинжлэх ухаан, технологийн сантай гарааны компаниудыг дэмжих чиглэлээр 4-р сарын 21-нд хамтран ажиллах санамж байгуулав.<br>3. Айтитиөү ХХК-тай "Science cafe" байгуулах, "Bridge" хөтөлбөр боловсруулах, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаа зохион байгуулах чиглэлээр 2-р сарын 25-нд хамтран ажиллах гэрээ байгуулав.<br>4. ХАА-н эдийн засаг, инновацийн хөгжлийн төвтэй МТ болон ХАА-н салбарын бизнес эрхлэгчдийг дэмжих хурдасгуур хөтөлбөр боловсруулах, тэдгээрийн оюуны өмчийг үнэлэх, технологи дамжуулах ажлыг зохион байгуулах чиглэлийн хүрээнд 5-р сарын 6-нд хамтран ажиллах санамж бичиг байгуулав.<br>5. "Монголын оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчдийн холбоо"-той гарааны компаниудын оюуны мэдлэгийг дээшлүүлэх, эрхийн хамгаалалт хийх тал дээр хамтран ажиллах гэрээ байгуулав.<br>6. "Монголын мэргэшсэн үнэлгээчдийн институт"-тай гарааны компаниудын үнэлгээ зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулах чиглэлийн хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулав.<br>7. "МҮХАҮТ"-тай гарааны компаниудыг сурталчлан таниулах, технологи дамжуулах арга хэмжээг зохион байгуулах чиглэлийн хүрээнд санамж бичиг байгуулав.<br>ГАРААНЫ КОМПАНИУДЫГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР САНАМЖ БИЧИГ 4, ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭГ 3 БАЙГУУЛЛАГАТАЙ ТУС ТУС БАЙГУУЛАВ. | |
| | | - | - Дүрэм журмын тоо<br>- Сургалтанл хамрагдсан ажилтны тоо | - | 3. Инновацийн төв, технологи дамжуулах төвийн менежментийг тодорхойлж, хүний нөөцийг бүрдүүлэх, холбогдох дүрэм журам боловсруулсан байна. | 1. Шинжлэх ухааны академитай хамтран Технологи инновацийн дэлгүүрийг байгуулсан бөгөөд дэлгүүрийн үйл ажиллагааны дотоод журам, бүтээгдэхүүн нийлүүлэх, технологи дамжуулах гэрээний ерөнхий загвар маягтыг хамтран баталж инноваци, технологи дамжуулах төвийн менежментийг тодорхойлов.<br>2. "Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль"-ийн төгсөх ангийн оюутан Б.Цэнд-ийг дадлагажигч оюутнаар ажиллуулан дадлагажуулж Технологи дамжуулах мэргэжилтний орон тоонд авч хүний нөөцийн бүрдүүлэлт хийсэн.<br>3. БНСУ-ын Оюуны Өмчийн газар, Койка-н хамтран зохион байгуулсан Оюуны өмчийн мэргэжилтнүүдийг оюуны өмчийг бүтээх, арилжаанд оруулах чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хэлтсийн технологи дамжуулалтын мэргэжилтнийг 09.26-30-ны хооронд хамруулав. | 50 |
| | | - | Сургалт, үйл ажиллагааны тоо | - | 4. "IT hub 2" -ийг байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн байна. | "ITHub-2"-ийг "Co-learning space" нэртэйгээр Ай Ти Ти Өү Ти ХХК-тай хамтран байгуулах гэрээг баталгаажуулсан. Гэрээ ёсоор тохижилтын ажлыг хийж хүлээлгэн өгөхөөр холбогдох журмын дагуу 2 удаагийн тендер зарлагдсан бөгөөд Санхүүжилтийн хүндрэл гарсан тул ITTO-ийн гэрээг цуцлан, тендер шалгаруулалтыг зогсоосон. Гэрээний хугацаанд "Playtime" хувцсаа өөрсдөө урлахуй танин мэдэхүйн арга хэмжээ болон "Нисгэгч хүүхдүүд клуб"-ын 2 удаагийн сургалтыг хамтран зохион байгуулсан. | 30 |
| 2.1.2 | Компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх | - | Салбар дэлгүүрийн тоо | - | 1. Шинжлэх ухаан, технологийн дэлгүүрээр дамжуулан 2-3 компанид инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучилж гарааны компани үүсэх боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. | Дархан, Эрдэнэт хотуудад салбар дэлгүүрүүд, Завхан, Хөвсгөл аймгуудад жижиг лангуунууд нээгдэн ажиллаж байна. | 30 |
| | | - | Бүтээгдэхүүний тоо, нэр төрөл | - | 2. Инновацын дэлгүүрийн бүтээгдэхүүний нэр | 2022.12.21-ний байдлаар 81 нэр төрлийн 2689 ширхэг бүтээгдэхүүн борлуулж 24,308,700 төгрөгийн орлоготой ажиллав. Жилийн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрлийг 10%-иар нэмэгдүүлсэн байна. | борлуулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 100% тай байна. Нийт 131 нэр төрлийн бүтээгдэхүүнтэй болсон ба бүтээгдэхүүний нэр төрлийг 10%-иар нэмэгдүүлэв. | |
| **Мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадвар олгох бүх нийтийн шалгалт, сургалтуудыг зохион байгуулах** | | | | | | | |
| **Зорилт 3.1** Олон улсын стандартын шалгуур үзүүлэлтэд суурилсан мэдээллийн технологийн ур чадвар, мэдлэгийг үнэлэх олон улсын шалгалтыг зохион байгуулах | | | | | | | |
| 3.1.1 | МТИШ-ыг зохион байгуулах, тайлагнах, хамтын ажиллагаа өрнүүлэх, сургалт, семинар зохион байгуулах | | Хамтран ажилласан байгууллагын тоо | | 1. Шалгалт нэвтрүүлэх чиглэлээр 1-2 байгууллагатай хамтран ажилласан байна. | "Эрдэнэт үйлдвэр"" ТӨҮГ -т МТ-ийн инженерийн шалгалтыг нэвтрүүлэх, хамтын ажиллагаа эхлүүлэх зорилгоор 2022.03.10-ны өдөр туршилтаар, 2022.04.23-ны өдөр албан ёсоор Мэдээллийн технологийн инженерийн шалгалтыг тус тус зохион байгуулав.<br>Туршилтын болон албан ёсны шалгалтад нийт 32 шалгуулагч хамрагдсан бөгөөд үүнээс албан ёсны шалгалтад 11 шалгуулагч хамрагдсанаас 10 шалгуулагч буюу 91% нь амжилттай дүн үзүүлэн олон улсын гэрчилгээ гардан авав.<br>Шалгалтын үр дүнд үндэслэн тус байгууллагад дараах 2 чиглэлээр арга хэмжээ авах санал хүргүүлэв. Үүнд:<br>1. Мэргэжил харгалзахгүйгээр Мэдээллийн технологийн болон мэргэшүүлэх сургалтуудад ажилтан, албан хаагчдаа хамруулах;<br>2. Ажилтан, албан хаагчдын мэдлэг ур чадварыг тодорхойлох шалгалтуудад тогтмол хамруулж, дутагдаж буй мэдлэг ур чадварыг тодорхойлон, сайжруулах арга хэмжээ зохион байгуулах; | 50 |
| | | -- | шалгуулагчдын тоо, тэнцэгчдийн хувь | - | 2. МТИШ-ыг 2 удаа зохион байгуулж 160-180 хүртэл шалгуулагч хамруулсан байна. | МТИШ-ыг нийт 2 удаа зохион байгуулсан бөгөөд 218 хүн бүртгүүлснээс 208 шалгуулагч хамрагдаж, 68 шалгуулагч тэнцэв. Мэдээллийг 2021 онтой харьцуулахад шалгуулагчдын тоо 92.2%-иар, тэнцэгчдийн тоо 10.7%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| | | | -Танилцуулах семинарын тоо<br>-Оролцогчдын тоо | - | 3. Шалгалт танилцуулах семинарыг 1 удаа зохион байгуулж нийт 300-400 оролцогч хамруулан, хөдөө орон нутгаас шалгалтад хамрагдагчдын тоог 5%-иар нэмэгдүүлсэн байна. | Япон улсын IPA байгууллагын дэмжлэгтэйгээр Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймаг, МТҮП-ын инкубатор компаниуд, Хаан банк, Жи мобайл ХХК-ийн ажилтан, албан хаагчид болон ХААИС-ийн оюутнуудад нийт 6 удаагийн "МТ-ийн инженерийн шалгалт"-ыг танилцуулах семинар зохион байгуулав. Семинарт нийт 408 оролцогч хамрагдав. Хөдөө нутгаас шалгалтад хамрагдагчдын тоо 43.75 хувиар өсөв. | 100 |
| | | - | Асуултын тоо, чанар | - | 4. Шалгалтын асуулт хандивлах тоо, чанарыг өмнөх оноос 10%-иар нэмэгдүүлсэн байна. | ОУ-ын асуулт боловсруулагчдын 33, 34 дэх удаагийн уулзалтад онлайнаар оролцож, МТ-ийн инженерийн шалгалтын зөвлөл (ITPEC)-д нийт 41 асуулт хандивлав. Монгол улс 2022 онд нийт 19 асуулт тэнцүүлж, чансаагаараа гишүүн орнуудын хэмжээнд 4-р байрт шалгарав. Тэнцсэн асуултын тоог өмнөх онтой харьцуулахад 11,8% -иар нэмэгдэв. | 100 |
| | | - | Номын тоо | - | 5. Ном гарын авлага гаргаж, олны хүртээл болгосон байна. | Мэдээллийн технологийн инженерийн суурь шалгалтад бэлтгэх номын VOL1 буюу технологийн хэсгийг орчуулж, | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дуусгав. Тус ном нь 7 бүлэг 476 хуудастай. | |
| 3.1.2 | ICDL шалгалтыг зохион байгуулах, тайлагнах, хамтын ажиллагаа өрнүүлэх | - | Хамтран ажилласан байгууллагын тоо | - | 1. Шалгалт нэвтрүүлэх чиглэлээр 1-2 байгууллагатай хамтран ажилласан байна. | ICDL шалгалтын цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:<br>- Шалгалт танилцуулах семинарыг Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ЗДТГ-т 2 удаа, МУБИС 1 удаа, ХААИС 1 удаа, ICT групп 1 удаа тус тус зохион байгуулав.<br>Нийт оролцогчдын тоо -25<br>Семинарын үр дүнд албан ёсны шалгалтад 8 шалгуулагч хамрагдав. | 100 |
| | | - | Туршилтын шалгалт болон оролцогчдын тоо | - | 2. Шалгалтын агуулгыг ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрт оруулах ажлыг эхлүүлж 1-2 дунд сургуульд туршиж эхэлсэн байна. | 1. ICDL шалгалтын цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажлуудыг гүйцэтгэв. Үүнд:<br>- Шалгалт танилцуулах семинарыг Сэлэнгэ аймгийн Шаамар суманд 2 удаа зохион байгуулж, 15 оролцогч хамруулав.<br>2. ICDL-ийн туршилтын шалгалтыг 2 удаа зохион байгуулж, ЕБС-ийн 38 сурагчийг хамруулав. Тус шалгалтад 12 сурагч буюу нийт сурагчдын 31,7 % нь тэнцсэв. | 30 |
| | | - | - Шалгалт зохион байгуулсан тоо<br>-Оролцогчдын тоо | - | 3. Шалгалтыг 2 удаа зохион байгуулж, 20 хүртэлх шалгуулагч хамруулан тэнцэгчдийн чанарыг 5-иар нэмэгдүүлсэн байна. | "Компьютерын хэрэглээний гэрчилгээ олгох шалгалт"-ыг нийт 2 удаа зохион байгуулж, 19 шалгуулагч хамруулсан бөгөөд нийт шалгуулагчдын 52.6 % нь амжилттай дүн үзүүлэн тэнцэв.<br>2021 онтой харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна. | 100 |
| 3.1.3 | TOPCIT шалгалтыг зохион байгуулах, тайлагнах, хамтын ажиллагаа өрнүүлэх | - | Хамтран ажилласан, семинар хийсэн байгууллагын тоо | - | 1. Шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр МТ-ийн салбарын 1-2 компанитай хамтын ажиллагаа эхлүүлсэн байна. | Топсит шалгалтыг нэвтрүүлэх чиглэлээр:<br>- Шалгалт танилцуулах семинарыг 8 байгууллагад зохион байгуулав.<br>- Юнител ХХК-тай хамтын ажиллагаа өрнүүлж тус байгууллагын 1 ажилтныг шалгалтад хамруулав. | 50 |
| | | - | - Шалгалт зохион байгуулсан тоо<br>-Оролцогчдын тоо | - | 2. Шалгалтыг 1 удаа зохион байгуулж 30 хүртэлх шалгуулагч хамруулсан байна. | Мэдээллийн технологийн практик ур чадварын шалгалтыг 1 удаа (ТОПСИТ) зохион байгуулж, 27 шалгуулагч хамруулав. Нийт оролцогчдын 44.5 хувь төрийн байгууллага, 48.1 хувь төрийн бус байгууллага, 7.4 хувь нь оюутан байв. Шалгалтын үр дүнг харвал:<br>- Анхлан суралцагч-23<br>- Суурь мэдлэгтэй суралцагч- 4<br>- Өрсөлдөхүйц чадвартай- байхгүй<br>- Мэргэжлийн түвшин- байхгүй<br>- Зөвлөх түвшин- байхгүй | 90 |
| 3.1.4 | Байгууллагын захиалгат шалгалтуудыг зохион байгуулах | - | - Шалгалт зохион байгуулсан тоо<br>-Оролцогчдын тоо | - | Аттестчилал болон туршилтын шалгалтуудыг тус бүр 1 удаа зохион байгуулж, гарсан үр дүнд үндэслэн холбогдох сургалтыг зохион байгуулсан байна. | "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, Багахангай дүүргийн ЗДТГ, Хангай цогцолбор сургууль дээр МТИШ-ыг туршилтын журмаар 3 удаа зохион байгуулав. Туршилтын шалгалтад нийт 37 шалгуулагч хамрагдсан бөгөөд 40.5% нь амжилттай дүн үзүүлэв. Шалгалтын үр дүнг нэгтгэн санал, дүгнэлт гарган байгууллага тус бүрд танилцуулав. Туршилтын шалгалтын үр дүнд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас албан ёсны шалгалтад 11 шалгуулагч хамрагдан 90.9%-ийн амжилт үзүүлэв. | 30 |
| **Зорилт 3.2** Төрийн албан хаагчид болон зорилтот бүлэгт зориулан мэдээллийн технологи ашиглах чадвхыг сайжруулах сургалт зохион байгуулах | | | | | | | |
| 3.2.1 | Үндсэн болон захиалгат сургалтыг зохион байгуулах | - | Сургалтын болон оролцогчдын тоо | - | 1. Бүх нийтийн МТ-ийн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг улиралд 1 удаа | Бүх нийтийн МТ-ийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор нийт 5 удаагийн сургалтыг зохион байгуулж, 31 суралцагч хамруулав. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж, нэг сургалтад 10-аас доошгүй суралцагч хамруулсан байна. | | |
| | | - | -материалыг цахим сургалтын модуль гаргах<br>- Видео хичээл | - | 2. Байгууллагын үндсэн 2 сургалтын материалыг цахим сургалтын модуль хэлбэрээр бэлтгэж, олны хүртээл болгосон байна. . | - "Мэдээллийн аюулгүй байдал" болон "HTML&CSS" нийт 26 видео бичлэгийг засварлаж цахим сургалтын контентын бэлтгэл ажиллагааг хангасан бөгөөд үндсэн сургалтуудын агуулгын модуль бэлтгэн, мөрдөн ажиллаж эхлээд байна.<br>- Цахим сургалтын сан бий болгох зорилгоор Миний кодын эхлэл болон Бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын бичлэгийг сэдэв бүрээр ангилан видео хичээлийн сан үүсгэв. Санд 2 чиглэлийн 24 цагийн сургалт байна. | 70 |
| | | - | Сургалтын болон оролцогчдын тоо | - | 3. Хамтарсан болон байгууллагын захиалгат сургалтыг улиралд 1 удаа зохион байгуулж, нэг сургалтад 15-аас доошгүй суралцагч хамруулсан байна. | Нийт 3 байгууллагатай хамтран 4 удаагийн сургалт зохион байгуулж 450 оролцогч хамруулав. Үүнд:<br>- Winner consulting ХХК-тай хамтран бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, Дижитал маркетинг стратеги аргачлал<br>- Инно плас ХХК-тай хамтран "iDeveloper" сургалт<br>- Азийн хөгжлийн банктай хамтран БМДИ-ийн төслийн сургалт | 90 |
| | | - | - Шалгалт зохион байгуулсан тоо<br>-Оролцогчдын тоо | - | 4. Шалгалтанд бэлтгэх сургалт зохион байгуулж 20-оос дээш суралцагч хамруулан тэнцэгчдийн чанарыг 5 хувиар нэмэгдүүлсэн байна. | Суурь шалгалтад бэлтгэх сургалтыг 1 удаа танхим болон онлайн хосолсон хэлбэрээр зохион байгуулж, 8 суралцагч хамруулав. Сургалтын контентыг видео хэлбэрт оруулсан бөгөөд зохиогчийн эрхийн асуудалтай холбоотойгоор олон нийтэд цацаагүй. Сургалтад хамрагдагчдаас 5 хувь нь шалгалтад тэнцсэн амжилт үзүүлэв. | 30 |
| | | - | Дотоод үйл ажиллагаанд танхим ашигласан тоо | - | 5. Холбогдох нэгжийг сургалт зохион байгуулахад шаардлагатай дэд бүтцээр хангаж ажилласан байна. | 5. Холбогдох нэгжийн 178 цагийн 56 арга хэмжээ зохион байгуулахад шаардлагатай дэд бүтцээр хангаж ажиллав. Үүнд:<br>- ИТСХХ - 60 цагийн 23 арга хэмжээ<br>- ТУСМХ - 82 цагийн 21 арга хэмжээ<br>- ЗУХ -36 цагийн 12 арга хэмжээ | 100 |
| 3.2.2 | Өсвөрийн зохион бүтээгчдийн сургалт | - | Сургалтын болон оролцогчдын тоо | - | Гурван төрлийн сургалтыг тус бүр 2 удаа зохион байгуулж нийт 60 суралцагч хамруулсан байна. | Нисгэгч хүүхдүүд сургалтыг 2 удаа зохион байгуулж 40, "Сансарт илгээх ил захидал" арга хэмжээг 9 удаа зохион байгуулж 533, "Зугаатай шинжлэх ухаан" сургалтыг 4 удаа зохион байгуулж 31, "Кодинг+Инженерчлэл" багц хөтөлбөрийн сургалтыг 8 удаа зохион байгуулж нийт 130, "Өсвөрийн сансрын инженер" анхан шатны сургалтыг 5 удаа зохион байгуулж 47, "Science EQ" анхан шатны сургалтыг 4 удаа зохион байгуулж 36 нийт 6 ТӨРЛИЙН АРГА ХЭМЖЭЭГ 32 УДАА ЗОХИОН БАЙГУУЛЖ 817 ХҮҮХЭД ХАМРАГДСАН БАЙНА. | 100 |
| **Судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, статистик мэдээлэл гаргах** | | | | | | | |
| **Зорилт 4.1** Судалгаа хийж, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх | | | | | | | |
| 4.1.1 | Бүтээгдэхүүний инноваци | - | Сургалтын тоо | - | 1. Өгөгдөл боловсруулах, Хиймэл оюун, Мэдээллийн аюулгүй байдал, Өндөр технологи, | 1. Өгөгдөл боловсруулах чиглэлээр "Паблик Лаб Монголиа" ТББ-тай хамтран 2022.04.25-наас 21 хоногийн турш үргэлжлэх "Youth Mappers 2022" Нийслэл Улаанбаатар хотын зураглал, өгөгдөл боловсруулах | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Инновацийн тэргүүлэх салбар, Бүтээлч үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа хөгжүүлэлтийн 3-аас доошгүй судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. | хөтөлбөрийг хамтран зохион байгуулав. Уг хөтөлбөрт 4 их сургуулийн 30 оюутан буюу 6 баг оролцож 3 долоо хоногийн турш 872,785 өгөгдлийг openstreetmap дээр цуглуулсан байна.<br>2. Судалгаа хөгжүүлэлтийн чиглэлээр "Мэдээлэл, технологийн үндэсний паркын инкубатор хөтөлбөрт хамрагдсан гарааны компаниудыг систем динамикийн загвараар судлах нь" судалгааны өгүүллийг ШУТИС-ийн системийн инженерчлэлийн багш нартай хамтран бичиж, эрдэм шинжилгээний эмхэтгэл сэтгүүлд хэвлүүлсэн.<br>3. "Инновацийн үйл ажиллагаа дагнан эрхэлдэг төрийн байгууллагын эрх зүйн байдал, тулгамдсан асуудал" сэдвээр хууль зүйн судалгааны ажил хийж Отгонтэнгэр их сургуулийн хууль зүйн сургуулийн эрдэмтэн багш нараар хянуулсан. Уг судалгааны ажлыг байгууллагын удирдлага болон ажилтан, албан хаагчдад танилцуулсан. | |
| | | - | | - | 2. Википедиа, мобайл апп, төрийн үйлчилгээ цахимжуулах чиглэлээр 2-оос доошгүй судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. | 1. "Инновацийн 7 хоног 2022" арга хэмжээ 2022.05.16-21-ний өдрүүдэд МТҮП-д зохион байгуулагдах болсонтой холбогдуулан Шинжлэх ухаан технологийн сантай хамтран "Innonight" буюу Инноваци, бизнесийн туршлага хуваалцах арга хэмжээг 2022.05.17, 19-ний өдрүүдэд зохион байгуулсан. Уг арга хэмжээнд урилгаар 30 хүн, цахимаар 44 хүн нийт 74 хүн оролцож санал солилцсон байна.<br>2. Бүх нийтийн мэдээллийн технологийн мэдлэгийг сайжруулах зорилготой БНСУ-ын Үндэсний мэдээллийн нийгэмлэгийн агентлаг (National Information Society Agency)-ын буцалтгүй тусламжаар 52 дахь "Мэдээлэл хандалтын төв" (IAC)-ийн төслийг амжилттай хэрэгжүүлж, 12.15-нд нээлтийн ёслолын арга хэмжээг зохион байгуулав. Цаашид төвийн үйл ажиллагааг хариуцах ажлыг ТУСМХ-т шилжүүлэв.<br>Нийт 29 төрлийн 1021 монгол аппликейшн, 323 хөгжүүлэгчдийн судалгааг өргөжүүлэн мэдээллийн бааз үүсгэв.<br>Үүнд: education - 2, business -1, finance- 1, Entertainment-4 аар нэмэгдүүлэв.<br>Хөдөө аж ахуйн салбарын апп хөгжүүлэлт байхгүй байгаа тул инкубаторын зорилтод салбарыг ХАА чиглэлийн компаниудыг элсүүлэх боломжтой гэж үзсэн бөгөөд үр дүнд үндэслэн зорилтот элсэлтийг Ухаалаг хөдөө аж ахуй чиглэлд зохион байгуулсан. | 30 |
| | | - | | - | 3. ШУ Танин мэдэхүй, цахим технологийн чиглэлийн энтертэйнмэнт төсөл 1-ээс доошгүйг хэрэгжүүлсэн байна. | 1. Олон нийтийн мэдээллийн технологийн салбарын ойлголтыг нэмэгдүүлэх, сүүлийн үеийн тренд технологийн талаар мэдээлэл хүргэх зорилготой "Tech buzzword" төслийн хураангуйг боловсруулав. Төслийн | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд технологийн салбарт тренд болж буй үг хэллэг тайлбарласан контент бэлтгэж нийт 6 удаа сошиал хуудсаар олон нийтэд цацав. | |
| 4.1.2 | Маркетингийн инноваци | - | | - | Сошиал маркетинг, CRM, маркетингийн автоматжуулалтын чиглэлээр 1-ээс доошгүй сургалт, судалгаа, төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. | Инновацийн дэлгүүрийн фэйсбүүк хуудасны мессенжерийн автоматжуулалтыг "дэлгүүрийн үйл ажиллагаа", "дэлгүүрийн байршил" мөн хэрэглэгчтэй шууд холбогдох байдлаар тохируулан хийсэн. Уг мессенжерийн автоматжуулалтаар 15 хүнд автоматаар хариу илгээсэн байна. | 0 |
| 4.1.3 | Үйл ажиллагааны инноваци | - | | - | Ажлын төлөвлөлт, гүйцэтгэлийн орчин үеийн шийдлийг байгууллага болон гарааны компаниудад нэвтрүүлэх, технологи дамжуулах чиглэлээр 1-ээс доошгүй төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна. | 1. Монголын цахилгаан холбоо ХХК-тай хамтран гэрээний төсөл болон 21 аймагт IT HUB байгуулах төслийн саналыг тус тус боловсруулав.<br>2. Байгууллагын сургалтын үйл ажиллагаанд инноваци хийх зорилгоор АНУ-ын Xtremelabs компанид хамтран ажиллах санамж бичгийг 2022.09.07-нд байгуулав. Санамж бичгийн хүрээнд Xtremelabs-аас санал болгож буй бүтээгдэхүүн, зөвлөх үйлчилгээ, МТ-ийн сургалтын шийдлүүдийг МУ-д нутагшуулахаас гадна МТҮП-ын сургалтын үйл ажиллагаа өргөжин бүтээгдэхүүний инноваци хийгдэнэ. Санамж бичгийн хүрээнд эхний промошн сургалтын саналыг Xtremelabs-аас манайд ирүүлсэн ба ТУСМХэлтэст танилцуулан Xtremelabs-тай холбоотой үйл ажиллагааг бүхэлд нь ТУСМХэлтэст шилжүүлэв. | 30 |
| 4.1.4 | Бүтэц, зохион байгуулалтын инновацийн чиглэлээр | - | | - | Ажилчдын сэтгэл ханамжийг дээшлүүлэх чиглэлээр нэг төсөл хэрэгжүүлсэн байна. | Ажилтнуудын өргөн ашигладаг хэрэглээний программын мэдлэгийг сайжруулах зорилгоор "Google Workspace Hack" гарын авлагыг Gmail, Drive, Meeting, Calendar гэсэн 4 агуулгын хүрээнд бэлтгэж гаргав. | 0 |
| 4.1.5 | Гарааны бизнес хөгжүүлэх | - | | - | 1. Инкубаторын багц үйлчилгээтэй холбоотой хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа хийж, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн шинэ үйлчилгээ нэвтрүүлсэн байна. | 1.Инкубаторын багц үйлчилгээг шинэчлэх зорилгоор инкубаторын компаниудаас судалгаа авч үр дүнг үндэслэн инкубаторын журамд нэмэлт өөрчлөлт оруулан 06. 20-оос эхлэн мөрдөн ажиллаж эхлэв. Өмнөх оны багц үйлчилгээ 61.298.000 байсан бол шинэчлэгдсэн журмаар 63 сая болж нэмэгдэв. | 30 |
| | | - | | - | 2. Инкубаторын төгсөгчид болон бойжиж буй компаниудын бүтээгдэхүүн үйлчилгээний судалгааг гаргасан байна. | 1. Инкубаторын үйл ажиллагааны чиглэлд судалгаа хийж зорилтот инкубаторын салбарыг Хөдөө аж ахуй, Аутсорсинг, Ахисан түвшний инкубаторын сонгон шалгаруулалт явуулав. Сонгон шалгаруулалтын хүрээнд календарчилсан төлөвлөгөө гарган танилцуулав.<br>2. Инкубаторын 2003-2021 онуудад төгссөн компаниудтай холбогдож төгсөгчдийн холбоог байгуулав. Төгсөгчдийн холбоонд нийт 11 компанийн 20 төлөөлөл байна. Холбооны гишүүдэд инкубаторын шинэ, шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг танилцуулж технологийн арга хэмжээнүүдийн мэдээллийг тогтмол хүргэн холбогдох судалгааг цахимаар явуулав. Компаниудын | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүтээгдэхүүн үйлчилгээний судалгааг явуулж танилцуулга бэлтгэв." | |
| | | - | | - | Гарааны бизнесийг дэмждэг экосистемийн судалгааг Мэдээлэл, Технологийн салбарын хүрээнд хийж гүйцэтгэсэн байна. | Боловсрол Шинжлэх Ухааны Яамны захиалгаар ЗСДС ТББ-аас гүйцэтгэж буй "Инновацыг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмждэг үндэсний тогтолцооны жишиг загвар боловсруулах нь" судалгааны ажилд Паркыг төлөөлөн оролцсон. Судалгааны ажил нь 2022.04.01-05.27 хүртэл хэрэгжсэн бөгөөд судалгааны үр дүнг Паркын ажилтан, албан хаагчдад танилцуулсан. Залуу судлаачдыг дэмжих сангаас судалгааны тайланг эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлж нийтийн хүртээл болгоно. | 50 |
| 4.1.6 | Салбарын хүний нөөцийн ирээдүйн эрэлтийн судалгаа хийх, хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах | - | Судалгааны ажил | - | 1. Шинэ төрлийн шалгалтуудыг нэвтрүүлэх боломжийг судлах, үр дүнг танилцуулсан байна. | "Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын шалгалт" (SG)-ын агуулгатай танилцав. Шалгалт нь МТ-ийн инженерийн суурь шалгалттай ижил 2 дугаар түвшний шалгалт бөгөөд агуулгын хувьд 4 сэдвийн хүрээнд шалгуулагчдын мэдлэг, ур чадварыг шалгадаг. Судалгааг дүгнэхэд шалгалтын агуулгын нэг хэсэг нь япон улсын мэдээллийн аюулгүй байдлын чиглэлийн хууль, бодлого дүрэм, журамд үндэслэдэг учраас Монгол улсад нэвтрүүлбэл шалгуулагчид энэ чиглэлийн асуултуудад унах магадлалтай гэж үзэж байна. | 30 |
| | | | Судалгааны ажил | - | 2. Төрийн албан хаагчдын мэдлэгийн түвшинг тодорхойлох судалгаа хийж, судалгааны үр дүнд үндэслэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл ажиллагааг хангасан байна. | Төрийн албан хаагчдын судалгааг нийт төрийн 30 гаруй байгууллагад хийж судалгааны үр дүнд дараах арга хэмжээг зохион байгуулав. Үүнд:<br>1. Дорнод аймгийн Дорнод их сургуулийн оюутан, багш, ажилтнуудын дунд Мэдээллийн аюулгүй байдлын 2 цагийн сургалтыг онлайнаар зохион байгуулж, 9 оролцогч хамруулав.<br>2. Бүх нийтийн мэдээллийн аюулгүй байдлын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, албан тушаалын онцлогт тохирсон сургалтын агуулгыг боловсруулах, зохион байгуулах зорилгоор Централ дата ХХК-ийн захирал Н.Угтахбаяртай хамтран ажиллахаар тохиролцсон бөгөөд хэлэлцээрийн түвшинд байна.<br>3. Төрийн албаны зөвлөлийн МТ-ийн шалгалтад 150 асуултын санг хүлээлгэн өгөв. | 70 |
| **Зорилт 4.2** Салбарын статистик мэдээ нэгтгэх, холбогдох талуудыг мэдээллээр хангах | | | | | | | |
| 4.2.1 | Мэдээллийн сан баяжуулах | - | Статистик мэдээллийн шинэчлэлт | - | Инкубатор, Шалгалт, сургалтын статистик, инновацийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоон мэдээллийг баяжуулсан байна. | Инноваци технологийн чиглэлээр 11 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 436 хүн хамрагдсан бол арга хэмжээ 13 удаа, байгуулсан гэрээ 5, санамж бичиг 5, зөвлөгөө 7 удаа тус тус өгч ажилласан байна.<br>Сургалт, шалгалтын хүрээнд мэдээллийн санг дараах 10 төрөлд нэгтгэн гаргав. 2022 онд тоон мэдээлэл дараах байдалтай байна. Үүнд:<br>- 3 төрлийн олон улсын шалгалтад 254 шалгуулагч хамрагдаж 78 нь тэнцсэн байна. Шалгалтад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэнцэгчдийн чанарыг өмнөх онтой харьцуулахад МТИШ -ийн 3,1 дахин нэмэгдсэн бол ICDL шалгалтынх 14%-иар буурсан үзүүлэлттэй байна.<br>- 8 удаагийн туршилтын шалгалтад 99 шалгуулагч хамрагдаж 1 шалгуулагч нь тэнцсэн байна.<br>- Үндсэн болон байгууллагуудтай хамтран 12 удаагийн сургалтыг зохион байгуулж 542 суралцагч хамруулж гэрчилгээ олгосон байна.<br>- 13 удаагийн арга хэмжээг дангаар болон хамтран зохион байгуулж 10,712 оролцогч хамруулсан байна.<br>- 3 төрлийн 68 гэрээг боловсруулан байгуулав.<br>- 9 төрлийн журам ашиглаж байгаагаас 1 журам шинээр боловсруулж, 2 журам шинэчилсэн байна.<br>- 2 төрлийн 12 албан бичгийг боловсруулж, 950 байгууллагад илгээсэн бөгөөд 19 байгууллагатай нь сургалт, шалгалтын хүрээнд хамтран ажиллав.<br>- 1 гарын авлага боловсруулж 5 видео хичээлийн сан үүсгэв.<br>- 5 төрлийн дотоод судалгаа хийв.<br>- 2 байгууллагатай гадаад хамтын ажиллагаа үүсгэв.<br>- Танхим түрээсээр 63,948,000₮ -ийн орлого орсон бөгөөд өмнөх онтой харьцуулахад 4,7 дахин өссөн байна.<br>Дүгнэлт: Цаашид тоон мэдээллийг хөтлөхдөө өмнөх жилүүдийн тоон мэдээллийг оруулан үргэлжлүүлэн хөтлөх, өмнөх сар болон жилийнхтэй харьцуулан хувьчилж гаргах<br>2006-2022 онд үндсэн үйл ажиллагааны хүрээнд 11 чиглэлийн 40 сургалтад 2179 суралцагчид хамруулав. | 90 |
| | | | | | | "2005-2022" он хүртэл нийт 153 компани инкубаторын хөтөлбөрт хамрагдсан бол үүнээс амжилттай төгсөгч 53, шилдэг төгсөгч 14, хугацаанаас өмнө төгссөн-28, хасагдсан-43, үйл ажиллагаа явуулж байгаа-61 зогссон 74 компани байна.<br>Инкубатор компанийн хүний нөөцийн тоо 191 бол үүнээс Үндсэн-142, гэрээт-40, дадлагажигч-9. Компаниудын орлого-зарлагын мэдээлэл 12 сарын дундаж орлого-672,593,761 зарлага-617,629,800 байна. | |
| 4.2.2 | Салбарын бодлогын баримт бичгийн биелэлт, үр дүнг тайлагнах, холбогдох газарт хүргүүлэх | - | Тайлан мэдээллийг цаг тухай бүр тайлагнасан байдал | - | Тайлан мэдээллийг бэлтгэн цахимжуулсан байна. | 1. Байгууллагын 2021 оны тайлан болон ХХМТГ-ын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан ажлын биелэлтийг нэгтгэн, баталгаажуулж холбогдох дээд байгууллагад хүргүүлсэн.<br>2. "Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны талаар баримтлах бодлого "2017-2025"-ын 2021 оны биелэлт<br>3. МУЗГ-ын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг улирал болон хагас жилээр<br>4. Цахим хөгжил харилцаа холбооны яамны 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 03/470 тоот бичгийн дагуу | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлангийн нэгтгэлийг цахимаар болон албан тоотоор хүргүүлсэн. | |
| | | | | | | Инкубаторын болон Сургалт, шалгалтын үйл ажиллагааны статистик мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулсан. https://itpark.mn/?page_id=99 | |
| **МХХТ-ийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах** | | | | | | | |
| **Зорилт 5.1** Гадаад хамтын ажиллагаа | | | | | | | |
| 5.1.1 | Гадаад, дотоод ижил төстэй байгууллагуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх | - | Үйл ажиллагаа өргөжсөн байдал | - | 1. Хамтран ажилладаг байгууллагуудтай үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна. | ASPA ANNUAL CONFERENCE 2024-ийг зохион байгуулахаар төслийн санал боловсруулан хүргүүлэв. Нийт 16 хуудас. "НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал, Монгол улсын Гадаад харилцааны яам хамтран зохион байгуулсан "Монгол улсын цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ"-ний Үндэсний олон талт зөвлөлдөх уулзалтад оролцсон. Тус уулзалтад МТҮП-ын үйл ажиллагааны талаар танилцуулж Монгол улсын цахим худалдаатай холбоотой асуудлууд дээр санал оруулсан. | 70 |
| | | - | Үйл ажиллагаанд хамрагдсан оролцогчын тоо | - | 2. ОУ-ын хурал, зөвлөгөөн, арга хэмжээнд байгууллагаас 3-4 ажилтан оролцуулсан байна. | БНСУ-д болсон Азийн Шинжлэх Ухааны Паркын Холбоо (ASPA)-ны 25 дугаар их хуралд байгууллагаас 9 ажилтан хамруулсан. | 100 |
| | | - | Гишүүнчлэл сэргэж, шинээр элссэн байдал | - | 3. ОУ-ын байгууллагын гишүүнчлэл сэргээх, шинээр элсэх чиглэлээр ажлууд хийгдсэн байна. | 1. Сингапурын ICDL байгууллагад хүсэлт гарган 2022 оны гишүүнчлэлийн төлбөр /500$/ чөлөөлүүлэв. 2. Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас зохион байгуулж буй Төв Азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны (CAREC) инновацийн сүлжээний (CIN) нээлтийн онлайн хуралд оролцсон МТҮП-ын үйл ажиллагаа болон Монголын стартапын экосистемийн талаар танилцуулга хийв. Мөн Төв азийн бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны CAREC инновацийн сүлжээний CIN-д Монгол улсыг төлөөлөн Паркыг гишүүнээр элсүүлэх талаар хэлэлцэж тохиров. | 50 |
| 5.1.2 | Гарааны бизнес болон технологи дамжуулах | - | Арга хэмжээнд хамрагдсан компанийн тоо | - | 1.Инкубаторын компаниудыг гадаад зах зээл таниулах, төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлээр ажилласан байна. | Мэдээлэл, технологийн үндэсний парк, Азийн Шинжлэх Ухааны Паркуудын Холбоо хамтран Монгол-Солонгос хоёр улс хоорондын зах зээлийн мэдээлэл солилцох, компанийн түвшинд хамтын ажиллагааг дэмжих зорилгын хүрээнд “Бизнес аялал” уулзалт арга хэмжээ зохион байгуулагдаж, нийт 20 төлөөлөгч оролцож, 9 байгууллага илтгэл хэлэлцүүлж, инкубаторын 6 компани нетворкинг үүсгэн цаашид хамтран ажиллах нөхцөл бүрдэв. Гүүгл компанийн БНСУ-ын борлуулалт хариуцсан захирал Timothy Paolini-д байгууллагын болон инкубаторын компаниудын үйл ажиллагааг танилцуулав. | 100 |
| | | - | Арга хэмжээнд хамрагдсан компанийн тоо | - | 2. ОУ-ын хурал, зөвлөгөөн, арга хэмжээнд инкубатораас 1-2 | Азийн Шинжлэх Ухааны Паркын Холбоо (ASPA)-ны 25 дугаар их хурал БНСУ-ын Жэжү хотноо 2022.10.31 - 2022.11.02 хооронд зохион байгуулагдсан бөгөөд тус хуралд | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | компани оролцуулсан байна. | МТҮП-ын ахисан түвшний инкубаторын компани болох "Марчаахай" ХХК оролцож өсөх ирээдүйтэй "Шилдэг компани" шагнал авсан. | |
| | | - | -Зуучилсан компанийн тоо<br>-Бэлтгэл хангагдсан байдал | - | 3. Донор байгууллагад инкубаторын 1-2 компанийг зуучлах, хамтын ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажиллагааг хангасан байна. | 1. Азийн Шинжлэх Ухааны Паркын Холбоо (ASPA)-ны 2024 оны хурлыг Монгол Улсад зохион байгуулах эрх авсан.<br>2. "Цахим Байгаль" НҮТББ-ын төслийг танилцуулахаар БОАЖЯаманд албан бичиг, танилцуулга хүргүүлсэн. | 30 |
| 5.1.3 | Оюуны өмч, технологи дамжуулах, технопаркийн хамтын ажиллагаа | | Хамтын ажиллагаа эхлүүлсэн байгууллагын тоо | | 1. Оюуны өмч, технологи дамжуулах чиглэлээр 1-ээс доошгүй байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн байна. | 1. Дэлхийн оюуны өмчийн байгууллагаас зохион байгуулсан оюуны өмчийн цуврал цахим сургалтын 2 дахь сургалтад хамрагдав. Сургалтаар хөдөө аж ахуй, хүнсний салбарын инноваци, технологи оюуны өмчийн асуудал, бизнесийн боломжуудын талаар хэлэлцлээ.<br>2. CAREC инновацийн сүлжээний ажлын хүрээнд Startup blink-тэй холбогдон 2022 оны старт ап экосистемийн судалгааг авч Монголын мэдээллийг орчуулав. Орчуулгыг эх хувийн хамт newsletter форматаар хэлтсийн "Судалгаа" хавтаст Startup ecosystem нэртэйгээр байршуулав.<br>3. Зөвлөх багш Jacob-ийн оршин суух үнэмлэхний бэлдэц тасарсан тул хугацаа нь хойшилж 9 сард хүлээн авав. | 0 |
| | | | Мэдээ мэдээллээр ханган, зуучилж, технологи дамжуулах ажлыг эхлүүлсэн байдал | | 2. Хамтын ажиллагааны хүрээнд гарааны компаниуд болон салбарын компаниудыг мэдээ мэдээллээр хангах, зуучлах, технологи дамжуулах ажлыг эхлүүлсэн байна. | 1. "Оюуны өмч ба залуучууд: Ирээдүйнхээ төлөө зохион бүтээцгээе" үйл ажиллагааг ОӨГ, АНУ-ын элчин сайдын яам, Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн газар, Мэргэшсэн үнэлгээчдийн холбоо, ЖДҮГ-тай хамтран 4-р сарын 25-нд зохион байгуулж "Гүүгл компанийн оюуны өмчийн туршлага" сэдвээр Гадаадын зөвлөх мэргэжилтэн Жакоб илтгэл тавив. Уг үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн 104 төлөөлөл оролцов.<br>2. ТИСК /технологи, инновацийг дэмжих төвүүд/-ийн үйл ажиллагаанд хамрагдсан байдлын тайланг гаргаж Оюуны өмчийн газарт И.Мэйлээр хүргүүлсэн.<br>3. Гадаад хэргийн яамнаас зохион байгуулсан "Монгол улсын Цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээ" сэдэвт олон улсын онол практикийн хэлэлцүүлэгт оролцож Паркын үйл ажиллагаа хэрэгжүүлж буй төслийн талаар танилцуулан санал өгсөн.<br>4. Оюуны өмчийн зөвлөгөөг 7 хувь хүн, албан байгууллагад өгөв. | 90 |
| 5.1.4 | МТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх | - | Сургалтын тоо | - | Хурал, семинарт оролцох, зохион байгуулах ажлыг зохион байгуулсан тоо | EDM буюу ITPEC-ийн гишүүн орнуудын удирдлагуудын 14 дэх удаагийн уулзалтад байгууллагыг төлөөлөн 3 хүн онлайнаар оролцов. Уулзалтад нийт 7 орны 29 төлөөлөгч оролцов. Уулзалтаас гарсан үр дүн:<br>- Шалгалтын хуваарь: 2022.10,23, 2022.10.23, 2023.04.23, 2023.10.22, 2024.04.21, 2022.10.20 | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | - Удирдлагуудын уулзалт (EDM)-ын хуваарь: 2023.08.21 – 22-ны хооронд Вьетнам улсад, 2024.08 сарын сүүлээр Монгол улсад улсад зохион байгуулагдана.<br>- Асуулт боловсруулагчдын уулзалт (QFM): 2023.05.30 - 31-ний хооронд Монгол улсад, 2023.12 сард Филиппин улсад зохион байгуулагдана.<br>- Суурь шалгалтын e-learning онлайн сургалттай болсон.<br>- 2024 онд Япон улс ITPEC-ийн гишүүн орнуудтай ижил асуулттайгаар шалгалтыг зохион байгуулдаг болно.<br>- 2024 онд CBT буюу компьютерт суурилсан шалгалтыг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. | |
| **Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагааг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 6.1** Үйл ажиллагааг чиглэл бүрээр сурталчлах, олон нийтэд мэдээлэл хүргэх | | | | | | | |
| 6.1.1 | Гарааны бизнес хөгжүүлэх | - | -Төлөвлөгөө гаргах<br>-Контентын тоо<br>-Үзэсгэлэнг, арга хэмжээнд оролцсон тоо<br>-Үзэсгэлэн, арга хэмжээнд оролцуулсан компанийн тоо<br>-Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажилласан байдал | - | 1. Ажлын чиглэл бүрээр төлөвлөгөө гарган, хэрэгжүүлсэн байна.<br>2. Хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлж англи, монгол хэл дээр контент гаргасан байна.<br>3. Технологийн үзэсгэл+эн арга хэмжээнд 1-2 удаа оролцож, зохион байгуулсан байна.<br>4. Шаардлагатай хэвлэлийн эх болон контентыг бэлтгэн гаргасан байна. | Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллав.<br>Инкубатор компанийн үйл ажиллагааг сурталчлах, хамтран ажиллах зорилгоор дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>- Монголын инновацын 7 хоног арга хэмжээнд инкубаторын 4 компанийг үзэсгэлэнд оролцуулж үүний үр дүнд Space academy хамтран ажиллах санал авав.<br>- Аспа-с "Өсөх ирээдүйтэй шилдэг компани" номинацид шалгарсан Ахисан түвшний инкубатор Марчаахай компанийн үйл ажиллагааг сурталчлав. Хандалтын тоо-1968<br>- "Робот софт" компанитай хамтран байгууллагын чат бот-г ажиллагаанд оруулав. | 90 |
| 6.1.2 | Технологи дамжуулах | - | | - | | Хэвлэл мэдээллийн "Peak news" сайттай хамтран ажиллахаар болов. "Бидний тухай" сэдэвт 5 контент агуулгын хүрээнд гарсан бөгөөд санхүүгийн асуудалтай холбоотойгоор ирэх онд хийгдэхээр болов. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор нийт 7 контент, 517 эх бэлтгэлийн ажил хийгдэв. | 50 |
| 6.1.3 | МТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх | - | | - | | 1. Инноваци хөгжүүлэх боломж, шийдэл-2022 форумыг Нийслэлийн ЖДҮ-тэй хамтран зохион байгуулж, инкубаторын 3 компани, "IT business 2022 erdenet" үйл ажиллагаанд инкубаторын 4 компанийг оролцуулж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж, нетворкинг хийх боломжийг олгов.<br>2. Инновацийн дэлгүүрийн үйл ажиллагааг сурталчлах хүрээнд 12 бүтээгдэхүүний танилцуулгыг фэйсбүүк хуудаст байршуулах, 1:20 секундийн шторк бэлтгэн сошиал хуудсаар цацах зэрэг ажлын гүйцэтгэв. Хөгжүүлэлт болон хөтлөлттэй холбоотой ажлуудыг цаашид холбогдох нэгж нь /ИТСХХ/ хариуцан ажиллахаар болов. | 90 |
| | | | | | | МТ-ийн мэргэжилтнүүдийн ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Олон улсын шалгалт болон Сургалт | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохион байгуулах чиглэлээр 7 видео шторк хийгдэв. Хандалтын тоо-29080 | |
| 6.1.4 | Цахим хуудас болон сошиал хуудсуудыг мэдээ мэдээллээр баяжуулж, үр дүнг тайлагнах | - | Дагагчдын тоо | - | 1. Сошиал орчны үйл ажиллагааг эрчимжүүлж, дагагчдын тоог 20-30 хувиар нэмэгдүүлж, үнэ цэнэтэй контентуудыг гарган олны хүртээл болгосон байна. | 1. Байгууллагын цахим хуудасны хэрэглэгчдийн хандалт болон дагагчдын тоог тус тус 10 хувиар нэмэгдүүлж үнэ цэнтэй контент бүтээх ажлын хүрээнд инкубаторын 2, онцлох 2, сургалт 4, шалгалт 3, танхим ашиглалт 1 нийт 12 контент гаргав. | 50 |
| | | - | Хандалтын тоо | - | 2. Байгууллагын цахим хуудасны хэрэглэгчдийн хандалтыг 10 хувиар нэмэгдүүлсэн байна. | 2. Байгууллагын цахим хуудасны хэрэглэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлэв. Мөн онцлох үйл явдлын мэдээг сар бүр бэлтгэн 12 удаа оруулсан бөгөөд хагас жил болон 2022 онд хийгдсэн ажлуудыг нэгтгэн контент гаргав. | 70 |
| | | - | Компаниудын үйл ажиллагааг сурталчилсан байдал | - | 3. Байгууллагын болон инкубатор компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сард 1 удаа нийт 12 удаа сурталчилсан байна. | 3. Инкубаторын 13 компанийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон үйл ажиллагааг сошиал сувгуудаар сурталчилж, зохион байгуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээллийг цаг тухай бүр веб болон пэйжд байршуулан ажиллав. Хандалтын тоо-82300 | 70 |
| | | - | Хуулийн хэрэгжилтийг хангасан байдал | - | 4. Хэлтсүүд байгууллагын цахим хуудасны холбогдох мэдээллээ цаг тухай бүр шинэчилсэн байна. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу байгууллагын веб хуудасны цэсний зохион байгуулалт болон мэдээ, мэдээллийг бүрэн шинэчлэв. | 0 |
| 6.1.5 | Байгууллагын 50 жилийн ойн арга хэмжээ зохион байгуулах | - | ЕБС-иудад чиглэсэн үйл ажиллагааны тоо | - | 1. ЕБС-ийн 12-р ангийн сурагчдын дунд МТ миний амьдралд эссэ бичлэгийн уралдааныг нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулсан байна. | "Мэдээлэл, технологи-Миний амьдралд" сэдэвт эссэ бичлэгийн уралдааныг Сүхбаатар дүүрэгт зохион байгуулж, ялагчдыг тодруулсан бөгөөд энэхүү ажилд анализ хийсний үндсэн дээр илүү олон хүүхдүүдийг хамруулан өргөн хүрээнд зохион байгуулах зорилгоор "Миний кодын эхлэл" хакатон тэмцээнийг санаачлан 21 аймаг 9 дүүрэгт зохион байгуулахаар болсон юм. Одоогоор Сүхбаатар, Дорноговь, Дундговь аймаг болон Налайх, Багахангай, Сонгинохайрхан дүүргүүдэд зохион байгуулсан бөгөөд нийт 123 сурагчдад технологийн мэдлэг олгосон байна. | 50 |
| | | - | Хурал зөвлөгөөн зохион байгуулсан байдал | - | 2. Салбарын хүрээнд эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн зохион байгуулсан байна. | МТХХ-ны салбарын уламжлалт Мягмар гарагийн уулзалтыг сэргээн салбарын ахмад үеийн уулзалтыг Мидас ТББ-тай хамтран 4-р сарын 5-нд, байгууллагын ахмадуудын уулзалтыг 5-р сарын 2-нд тус тус зохион байгуулллаа. | 0 |
| | | - | Ном гаргасан байдал | - | 3. Байгууллагын түүхэн ном 250ш хэвлүүлэн олны хүртээл болгосон байна. | Байгууллагын түүхэн номын II дэвтэр гаргах ажлын хэсгийг 2022 оны 03 дугаар сарын 23 -ны өдрийн 1а-15 тоот тушаалаар байгуулж, 2014-2022 онуудын үндсэн үйл ажиллагааны чиглэлийн статистик мэдээ, зохион байгуулсан томоохон үйл явдлын мэдээ, мэдээлэл цуглуулж эмхэтгэсэн. Номын эхийг редактор хийлгэх болон хэвлүүлэх зардал өндөр тусч байгаа учир Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу хойшилсон болно. | 0 |
| | | - | Байгууллагын үйл ажиллагааг | - | 4. Байгууллагын дүр төрхийг шинэчлэн | Байгууллагын дүр төрхийг шинэчлэн таниулах ажлын хүрээнд нэр логотой | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | таниулах бүтээгдэхүүн, үйлчилгээ гарсан байдал | | таниулах 3 хүртэлх брэнд бүтээгдэхүүн, үйлчилгээ гаргасан байна. | бал, мемо цаас, салбарын алтан маркийг захирлын гарын үсэг тамгатайгаар, Байгууллагын эскиз зурагтай аяга, логотой 16gb флаштай бал, логотой бал дэвтэр, эскиз зурагтай том шоколад, байгууллагын логотой жижиг шоколад нийт 8 бүтээгдэхүүн гаргасан. "ХҮҮХДЭД ХҮРТЭЭМЖТЭЙ ТЕХНОЛОГИ" аяныг зохион байгуулах ажлын хэсгийг 2022.03.23-ны өдрийн 1а-16 тоот тушаалаар байгуулж, Жэй Си Ай Капитал салбар байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг зурах, төлөвлөгөө гаргах, урилга хэвлэлийн мэдээ бэлтгэн нийтлэх, стенд, веб баннер гаргах зэрэг ажлыг гүйцэтгэсэн. Үйл ажиллагаа 04.01-ний өдрөөс эхлэн 3 сарын хугацаанд зохион байгуулж, яамдууд, төр болон хувийн хэвшлийн байгууллагууд, их дээд сургуулийн төлөөлөл, аймаг сумдын хууль хүчний байгууллагууд зэрэг 60 гаруй байгууллага хамтран ажиллаж, хандив тусламж үзүүлэх, аянтай холбоотой баннер, мэдээ зэргийг өөрсдийн мэдээллийн хэрэгслэлээр түгээн дэмжиж ажилласан. Тус аяны хүрээнд 15 нэр төрлийн 200 гаруй технологийн хэрэгслүүд цугларсан бөгөөд гэмтэлтэй технологийн хэрэгслүүдийг засаж сэлбэх ажлыг ШУТИС-ийн Холбоо мэдээллийн сургуультай хамтран гүйцэтгэж байна. Ашиглах боломжтой технологийн хэрэгслүүдийг лабораторигүй нийслэлийн ЕБС-ын сургуулиудад хандивлах, ашиглах боломжгүй эд зүйлсийг технологийн хог хаягдал зориулалтаар устгах газарт хүлээлгэн өгөхөөр төлөвлөн ажиллаж байна. Аяны хаалтыг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулна. МТҮП-ын үйлдвэрчний эвлэлийн хорооноос гаргасан санаачилгыг дэмжин нийслэлийн автомашингүй өдрөөр "Нийслэлийн бизнес инновац хөгжлийн газар", Tu-shopping.mn байгууллагуудтай хамтран "KIDS TECH 2022" хүүхдийн баярын экспо зохион байгууллаа. Үйл ажиллагаанд хүүхдэд зориулсан технологийн бүтээгдэхүүн үйлчилгээ болон бусад бараа бүтээгдэхүүний танилцуулга, үзэсгэлэн худалдаа явагдаж нийт 12 байгууллага оролцож 1000 орчим хэрэглэгчид үзэж сонирхон, үйлчлүүлсэн. | |
| **Удирдлагын оновчтой бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| **Зорилт 7.1** Хууль эрх зүйн хүрээнд байгууллагын эрх ашгийг хамгаалах | | | | | | | |
| 7.1.1 | Хууль эрх зүйн маргаантай асуудлыг шийдвэрлэхэд байгууллагын эрх ашгийг хамгаалан ажиллах | - | Байгууллагын эрх ашиг хамгаалагдсан байдал | | Гэрээний зөрчил арилж, хуулийн хүрээнд байгууллагын эрх ашиг хамгаалагдсан байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын авлагатай нийт 16 байгууллага, Шүүхээс 3 байгууллагын иргэний хэрэг үүсгэн шалгаж байна. Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэсэн 3, Цагдаагийн байгууллагаар хаяг тодорхой болгохоор эрэн сурвалжлагдаж байгаа 5 байгууллага байна. "Дүйхэр тэргүүн" ХХК шүүхийн шийдвэр | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэх ажиллагаа явагдаж байгаа бол Колорфул квалити ХХК-д холбогдох шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай тогтоолыг гардаж аваад байна. | |
| 7.1.2. | Дүрэм журам, гэрээ шинээр боловсруулах, шинэчлэх, хянах | - | Гэрээ, дүрэм журмын баталгаажилт, хэрэгжилт | - | Байгууллагын дотоод үйл ажиллагаанд болон үндсэн үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй дүрэм, журам, гэрээ зэрэг баримт бичиг шаардлагын дагуу боловсруулагдан баталгаажсан байна. | 1.Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотой Хөдөлмөрийн дотоод журам, Ажил дүгнэх журам, Хөдөлмөрийн гэрээ, Ажлын байрны тодорхойлолт гэсэн 4 баримт бичгийг 2022.01.17-нд, Ёс зүйн дүрмийг 2022.03.28-нд тус тус шинэчлэн батлуулсан.<br>2. Байгууллагын хэмжээнд нийт 37 дүрэм, журам хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнээс бодлогын 3 баримт бичиг, захиргааны үйл ажиллагаатай холбоотой 13 дүрэм, журам, Инкубаторын үйл ажиллагаатай холбоотой 7 журам, шалгалт сургалтын үйл ажиллагаатай холбоотой 9 журам, бусад асуудлыг зохицуулсан 5 журам байна.<br>3. 2022 оны байдлаар нийт 170 гэрээ байгаагаас хамтын ажиллагааны 10, кластер1, ажил гүйцэтгэх 19, хүний нөөцийн 35, нууцын 19, инкубаторын 19, оффис түрээсийн 2 талт 6, оффис түрээсийн 3 талт 10, танхим түрээсийн 46, бусад 5 гэрээ байна. Энэ онд хийгдсэн гэрээнээс 18 нь дуусгавар болсон байна.<br>5. 2022 оны 1 сараас хойш нийт 7 байгууллагатай санамж бичиг байгуулсан байна./ШУТсан, ХАА-н эдийн засаг, инновацын хөгжлийн төв, Жэй Си Ай Капитал, XtremeLabs LLC, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим, БНСУ-ын Үндэсний Мэдээллийн нийгэмлэгийн Агентлаг, Founders Institute Mongolia/ | 90 |
| **Зорилт 7.2** Хүний нөөц болон олон нийттэй харилцах үйл ажиллагаа | | | | | | | |
| 7.2.1. | Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх | - | -Тушаал шийдвэр<br>-Гэрээ байгуулсан байдал | - | 1. Хүний нөөцийн бодлого төлөвлөлт хэрэгжсэн байна. /Хувийн хэрэг бүрдүүлэлт, шилжилт хөдөлгөөн, ажлаас чөлөөлөх, томилох, ажилтан шалгаруулж авах г.м/ | 1.Шинэчлэгдэн батлуулсан Хөдөлмөрийн дотоод журам, Ажил дүгнэх журмыг нийт ажилтан, албан хаагчдад танилцуулж гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд бүх ажилтан, албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн ажилтан, албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталгаажуулсан.<br>2. 35 ажилтан албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэн, шинэ гэрээ, Нууц хадгалах гэрээ, АБТ зэргийг тус бүрийн хавтаст байршуулсан.<br>3. 2022.12.21-ний байдлаар 9 ажилтан, албан хаагч өөрийн хүсэлтээс ажлаас чөлөөлөгдсөн бөгөөд 9 ажлын байрны зар явуулж, 7 ажилтан, албан хаагчийг зохих журмын дагуу ажилд томилсон бол ажил хавсран гүйцэтгэж байгаа 3 ажилтан, албан хаагч байна. | 100 |
| | | - | Мэдээлэл шинэчлэл | - | 2. Хүний нөөцийн мэдээллийн санг цаг тухай бүр шинэчлэгдсэн байна. | 1. Хүний нөөцийн мэдээллийн санг шинэчлэн, амралтын хуваарийг 1-р сард батлуулж 2022 оны ээлжийн амралтыг олгож дууссан бөгөөд 3 ажилтан албан хаагч зайлшгүй ажлын шаардлагын улмаас ээлжийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | амралтыг биеэр эдлээгүй бөгөөд амралтын цалинг нөхөн олгосон.<br>2. Байгууллагад нийт 36 ажилтан, албан хаагч ажиллаж байгаагаас жирэмсний амралттай 1, Хөдөлмөрийн гэрээтэй 29, Хөлсөөр ажиллах гэрээтэй 6 байна.<br>3. Нийт ажилчдын 40 хувь нь эрэгтэй, 60 хувь нь эмэгтэй ажилчид байгаа бөгөөд 35 хувь нь 35 хүртэлх насны, 35 хувь нь 36-50 насны, 30 хувь нь 51-ээс дээш насны ажилтан, албан хаагч байна. | |
| | | - | ХДЖ, АДЖ-ын хэрэгжилтийн байдал | - | 3. Ажлын цаг ашиглалт болон ажлын байрны дэг журмыг мөрдүүлэн ажилласан байна. /ХДЖ, АДЖ/ | 1.Ажилтан албан хаагчдын ажлын цагийн мэдээллийг динамик систем рүү бүртгэж, 7 хоног бүр танилцуулж ажилласан.<br>2. 2022 оны жилийн эцсийн байдлаар ажлын цаг ашиглалт муу 2 албан хаагчид цалингийн 20% хасах Сахилгын шийтгэл, ёс зүйн алдаа дутагдал гаргасан-4 албан хаагчид Сануулах сахилгын шийтгэлийг тус тус оногдуулсан.<br>3. Байгууллагад үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажилласан 13 ажилтан, албан хаагчийг төрийн болон салбарын, МЗХ-ны шагналуудад тодорхойлж "Алтан гадас" одонд 1, Салбарын жуух бичигт 1, МЗХ-ны шагналд 5 нийт 7 ажилтан албан хаагч шагнал хүртээд байна.<br>4. АДЖ-ын дагуу 2022 оны эхний хагас жилээр 5, жилийн эцсээр 3 нийт 8 ажилтан, албан хаагч урамшуулсан.<br>5. Нийт 13 ажилтанд ажлын үнэмлэх олгосон. | 90 |
| | | - | Судалгааны тоо | - | Ажилтан, албан хаагчдаас байгууллагын менежменттэй холбоотой сэтгэл ханамжийн судалгааг жилд 2 удаа зохион байгуулж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | 2022 оны байгууллагын менежменттэй холбоотой 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаанд давхардсан тоогоор 45 ажилтан албан хаагч хамрагдсан. Судалгаанд оролцогчдын 50-60% нь гүйцэтгэх болон нэгжийн удирдлагууд удирдах чадвар , мэдлэг боловсрол, биеэ авч явах соёл, бусдад хандах хандлага тус тус сайн, тулгарсан асуудлыг шийдвэрлэдэг гэж дүгнэсэн бол 40-45% нь удирдах чадвар, мэдлэг боловсрол, харилцаа хандлага дунд зэрэг гэсэн хариултыг өгсөн байна.<br>Санал хүсэлт:<br>1.Тайлан төлөвлөгөөнд зарцуулах цагийг багасгах,<br>2. Өвөл, хаварт оффис маш хүйтэн байдаг учир дулааны асуудлыг шийдэж өгөх.<br>3. Дийлэнх хүмүүст санал хүсэлт байхгүй байсан.<br>4. Цайны өрөөний тохь тухтай байдлыг нэмэгдүүлэх<br>5. Цалингийн мэдээллийг тогтмол хувийн мэйлээр авдаг байх | 90 |
| 7.2.2 | Байгууллагын хүний нөөцийн бодлогын хүрээнд сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулж хэрэгжүүлэх | - | Сургалтын тоо | - | Ажилтан, албан хаагчдыг мэргэшүүлэх болон харилцаа хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сургалтыг тус бүр 5-аас доошгүй | Албан бичиг хөтлөлт, Үйлчилгээний албан хаагчдын Ёс зүй, Санхүүгийн дархлаа, No smoking now, Нээлттэй өгөгдлийн талаарх үндсэн ойлголт, мэдлэг өгөх, Технологи Хүний эрх-Ёс зүй гэсэн 6 сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 72 Ажилтан, албан хаагч хамруулсан. | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулсан байна. | | |
| | | - | Хамрагдсан ажилтан, албан хаагчийн тоо | - | Гадаад, дотоодын урт богино хугацааны сургалт, семинарт 10-аас доошгүй албан хаагч хамруулсан байна. | 1.Дотоодын мэргэшүүлэх сургалтын хүрээнд Худалдан авах ажиллагааны А3-ын сертификат авах сургалтад -6, "ТӨСЛИЙН МЕНЕЖЕР буюу PMP болох арга зам" сургалтад -5, "Сошиал медиа" сургалтад -2, "Стар-Апдаа хэрхэн гадны хөрөнгө оруулалт татаж дэлхийд гарах вэ?" онлайн сургалтад -4, HDML&CSS сургалтад -2 нийт 19 ажилтан, албан хаагч хамрагдсан байна.<br>2.Залуу судлаачдыг дэмжих сангийн Инновацийг хөгжүүлэх үйл ажиллагааг дэмждэг, үндэсний жишиг загвар боловсруулах нь судалгааны ажилд ИТСХХ-ийн Технологи дамжуулах мэргэжилтэн 3 сарын хугацаатай ажилласан.<br>3. Салбар болон салбар дундын үйл ажиллагаанд байгууллагын оролцоог хангах хүрээнд Дархан-Уул аймагт Найрамдал төсөл арга хэмжээнд -1, "Эрдэнэт ШУ-ны парк ОНӨҮГ-ын нээлт" хэлэлцүүлэг семинарт-8, "Монголын эдийн засгийн чуулган 2022" хэлэлцүүлэгт -4, Оюуны өмч ба залуучууд - Ирээдүйнхээ төлөө бүтээцгээе" хэлэлцүүлэгт -13, Жендерийн ҮХ-ны хуралд -8, "ММТЭШ 2022" -2, МУ дахь цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудал хэлэлцүүлэгт- 2, зөвлөгөөнд -3, Дэлхийн жижиг дунд үйлдвэрийн өдөр үзэсгэлэнд- 5, ЦХХХЯ, ЖҮХ-ийн хэлэлцүүлэг-6 нийт 52 ажилтан, албан хаагч хамрагдсан байна.<br>4. Гадаадын мэргэшүүлэх сургалт үйл ажиллагааны хүрээнд БНСУ-д Хиймэл оюун ухаан боловсролын технологи сургалтад-2, Мэдээллийн аюулгүй байдал сургалтад-2, Цахим ур чадвар олгох төвийн мэргэшүүлэх сургалтад-1, Азийн шинжлэх ухааны паркуудын чуулганд- 8, Энэтхэг улсад ITEC- сургалтад 1 нийт 16 ажилтан, албан хаагч хамрагдсан байна. | 100 |
| | | - | Хөтөлбөрт хамрагдсан ажилтан, албан хаагчийн тоо | — | Байгууллагаас нэг ажилтан интрепренёр хөтөлбөрт хамруулсан байна. | Интрапренёршип хөтөлбөрийн хүрээнд Старт ап менежер Б. Долгионы ТОБЛО төслөөрөө 3-р сарын 17 хүртэлх хугацаанд хамрагдан зохих журмын дагуу чөлөөлөгдсөн. | 70 |
| 7.2.3 | Ажилчдын нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, хамт олны уур амьсгал сайжруулах арга хэмжээ зохион байгуулах | - | Үзлэгт хамрагдсан ажилтан, албан хаагчдын тоо | - | Ажилтан, албан хаагчдыг жилд 1 удаа эмнэлэгийн үзлэгт хамруулсан байна. | Улс даяар өрнөж буй Эрт илрүүлгийн эрүүл мэндийн үзлэгт бүх ажилтан, албан хаагчдыг хамруулахаар үзлэгийн мэдэгдэл ирсэн ажилчдад ажлын цагаар чөлөө өгч байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар 7 ажилтан, албан хаагч эрүүл мэндийн үзлэгтээ хамрагдаад байна. | 30 |
| | | - | Үйл ажиллагаа зохион байгуулсан байдал | - | Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиплагаа зохион байгуулсан байна. | Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд "Kids Tech 2022" арга хэмжээг зохион байгуулж ажилтан, албан хаагчдын хүүхдүүдийг бүрэн хамруулан зохион байгуулсан. | 50 |
| | | - | Үйл ажиллагаа зохион | - | Байгууллагын ахмадуудад жилд 1 | 2022.05.03-нд байгууллагын ахмадуудыг хүлээн авч, хүндэтгэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | байгуулсан байдал | | удаа хүндэтгэл үзүүлэх арга хэмжээ зохион байгуулсан байна. | үзүүлэх салбарын ойн медаль гардуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийт 56 ахмад хамрагдсан. | |
| | | - | Шийдвэрлэгдсэн өргөдлийн тоо | - | Өргөдөл хүсэлтийг цаг алдалгүй шийдвэрлүүлж дэмжлэг үзүүлсэн байна. | Цалингийн урьдчилгаа хүссэн 6, ажлаас чөлөөлөгдөх 10, буцалтгүй тусламж хүссэн-8, ажилд орохыг хүссэн-3, Цалинтай чөлөө хүссэн 6, Урт хугацааны чөлөө хүссэн-3 Тэтгэмж хүссэн-1, удаан жилийн нэмэгдэл хүссэн-1, Интерпренер болох-1, бусад-3 Нийт 42 өргөдөл хүсэлтийг цаг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан. | 100 |
| | | - | Үйл ажиллагааны тоо | - | Улиралд нэг удаа олон нийтийг хамарсан үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | Цасны баяр" болон Байгаль нуур Итгэлт хамбын аялал, Алтай таван богдын аялал, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдөр зэрэг үйл ажиллагаа зохион байгуулж, давхардсан тоогоор 10 орчим ажилтан, албан хаагч хамруулсан. | 30 |
| | | - | Үйл ажиллагаа зохион байгуулсан байдал | - | Ажилтан, албан хаагчдыг чийрэгжүүлэх, спортоор хичээллэхэд чиглэсэн үйл ажиллагаа зохион байгуулсан байна. | 1. Мэргэжлийн боксын дасгалжуулагч болон идэвхтэй хөдөлгөөний клубийн багш урьж 2 удаагийн танилцуулах сургалт зохион байгуулсан.<br>2. Өдөр тутмын дасгал хөдөлгөөнийг хэвшүүлэхээр өдөрт 2 удаа алжаал тайлах ая тавьж дасгал хөдөлгөөн хийхийг уриалан зохион байгуулж байна. | 50 |
| **Зорилт 7.3** МТҮП-ын ашиглалт, санхүү төлөвлөлтийг сайжруулах | | | | | | | |
| 7.3.1 | Байгууллагын байрны талбай ашиглалт, тохижилтыг сайжруулах | - | Тохижилт, урсгал засвар хийгдсэн байдал | - | Гадна, дотно хаягжилт шинэчлэх, коридоруудын урсгал засвар тохижилтын ажил хийгдсэн байна. | 1. 2-р давхрын засвар тохижилтын ажлын хүрээнд хананы урсгал засвар хийх, коридорын дрож сэлбэж солих, байгууллагын түүхэн фото зургуудыг коридорын хананд байршуулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэв. Мөн оффист ажилчдын албан тушаал нэрийг байршуулсан.<br>2. 211 тоот танхимын засвар тохижилтын ажлын хүрээнд тааз засах, хананд бүхэлд нь хөшиг тогтоох, эйр кондишен засварлуулах, цонхны хагарсан шилийг битүүмжлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.<br>3. 302 тоот сургалтын танхимын тохижилтын ажлын хүрээнд хананд нь баннер тогтоогч болон хөшиг хийлгэв.<br>4. Складны нэг өрөөнд, захирал болон нарийн бичгийн өрөөнд, 303 тоот танхим зэрэгт урсгал засвар хийв.<br>5. Байгууллагын байрны 1-р давхрын коридорын хана, тааз, өрөөнүүдийн хаалга зэргийг засаж, гэрэлтүүлгийг бүрэн шинэчлэв.<br>6. Цахим ур чадвар олгох төслийн нэлттэй холбоотойгоор танхимуудад хогийн сав байршуулах, 2 хаалганы цоож солиулах, гишгүүр дрож байрлуулах гэх мэт тохижилтын ажил гүйцэтгэв.<br>7. Ирэх оны зорилтот түвшний төсөлд санал оруулах зорилгоор 3 давхрын дрож бүхэлд нь солих, эйр кондишен авах, 211 тоотод нэмэлтээр хаалга гаргуулах, 302 тоот сургалтын танхимын шилэн ханыг гүйдэг болгоход гарах зардлын тооцоог гарган удирдлагуудад танилцуулсан.<br>8. Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд гадаа үүд болон шатанд | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гулгаанаас сэргийлж дрож нааж бүх давхрын цонх дулаалж наах ажлыг зохион байгуулсан.<br>9. 216, 217,222, 223 тоот өрөөнүүдэд хэсэгчлэн салсан дрожнуудыг нааж зассан. | |
| | | | | | | Байгууллагын гадна авто зогсоолын төлбөртэй үйлчилгээ нэвтрүүлэх ажил СИМ ХХК-ийн захиалгын материал цаг хугацаандаа ирээгүйгээс удааширсан. 2022.06-р сард зогсоолын камер, хаалт, системийн тохируулгын ажил хийгдсэн. МТҮПарк, Гэрэгэ системс ХХК, СИМ ХХК 3 тал хамтын ажиллагааны гэрээ байгуулан зогсоолын системийг Гэрэгээгээр авахаар болсны дагуу Нийслэлийн замын хөгжлийн агентлагт авто зогсоолын тусгай зөвшөөрөл авахаар хүсэлт явуулсан боловч татгалзсан хариу өгсөн. Зогсоолын асуудлаар дахин цахилгаан автомашин цэнэглэгчийн хөгжүүлэлтийн талаар хүсэлт гаргасан ч хариу ирүүлээгүй. Нийслэлээс зогсоолынборжур орох, гарах гарц зэргийг шинэчилж өгсөн. Нийслэлийн авто зогсоолын тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий агентлаг Замын хөдөлгөөний удирдлагын төв болсон. Энэ байгууллага нь одоогоор үйл ажиллагаа жигдрээгүй учир зөвшөөрлийн асуудлаар хариу ирүүлээгүй үйл явц удаашралтай байна. | 70 |
| | | - | Тохижилт, урсгал засвар хийгдсэн байдал | - | 1,4-р давхрын АЦӨ-ний засвар хийгдсэн байна. | 1-р давхрын АЦӨ-нүүдийн тохижилтын хүрээнд цонх битүүмжлэх, хаалга шинэчлэх, тосгуур толь байршуулах зэрэг ажлыг гүйцэтгэв. | 50 |
| | | - | Талбай ашиглалтын байдал | - | "IThub 2"-ын тохижилтын ажил хийгдсэн байна. | Зохих журмын дагуу тендер зарлагдсан боловч ажил гүйцэтгэх компанийн санал ирээгүй бөгөөд бараа материалын үнийн өсөлттэй холбоотойгоор дахин зарлах боломжгүй болсон. Иймээс талбайг кластер төслийн хүрээнд Үндэсний дата төвд ашиглуулж байна. | 50 |
| | | - | Тендэр шалгаруулалт | - | Байгууллагын цахилгаан шатыг ашиглалтанд оруулсан байна. | Цахилгаан шатны нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа зарлан зохион байгуулснаас нэг сонгон шалгаруулалтад гомдол гаран шалгагдан буцаагдаж, 2 удаагийн зараар оролцогч ирээгүй. Бараа материалын үнийн өсөлттэй холбоотойгоор дахин зарлах боломжгүй болсон. | 50 |
| | | - | Хаяг шинэчлэгдсэн байдал | - | Байгууллагын гэрэлт хаягийг шилжүүлэн байрлуулсан байна. | Хэмнэлтийн хуулийн дагуу хийх боломжгүй болсон бөгөөд санхүүгийн бололцоонд тулгуурлан дээвэр дээр байрлах хаяг лого бүхий 4 самбарыг шинэчлэв. | 100 |
| | | - | Санал асуулга, үр дүн | - | Үйлчилгээ тохижилттой холбоотой санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэсэн байна. | Цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгаагаар 70-80% сэтгэл ханамжтай 20-25% сайжруулах шаардлагатай. Санал:<br>1. Үйлчлэгчдийн ажлын чанар, бүтээмжийг нэмэгдүүлэх, Инкубатор тусдаа үйлчлэгчтэй байх<br>2. АЦӨ-ний цэвэрлэгээний давтамжийг тогтмолжуулах, цаас, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | агааржуулагч г.м хэрэгслэлүүдийг тогтмол цэнэглэх<br>Дээрх саналын дагуу инкубаторын үйлчлэгчтэй болсноос гадна АЦӨ-ний эргэлт, хяналтын сайжруулсан. | |
| 7.3.2 | Санхүү бүртгэлийн үйл ажиллагааг хуулийн дагуу явуулах | - | Зөрчилгүй байх | - | 1. НББ-ийг холбогдох хууль, журмын дагуу хөтлөн, тайлагнаж зөрчилгүй ажилласан байна. | 1. 2021 оны аудитын зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т<br>2. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ЦХХХЯ болон ТӨБЗГ-т<br>3. ЦХХХЯамны дотоод аудитын санхүүгийн баримтад хийсэн үзлэгээр 100%<br>4. 2023 оны зорилтот түвшнийг батлуулав.<br>5. Татварын өрийн үлдэгдэл баталгаажуулалт<br>6. НББ-ийг холбогдох хууль, журмын дагуу хөтлөн, тайлагнаж зөрчилгүй ажиллаж байна.<br>7. Инновацийн дэлгүүрийн орлого 2022 оны төлөвлөгөөгөөр 19,8 сая төгрөг байхаар төлөвлөснөөс ХБГ-ээр 23.2 сая байна.<br>АТҮА-ны хүрээнд байгууллагын дотоод пейж хуудсаар нийт 64 зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан. | 100 |
| | | - | Эд хөрөнгийн баталгаажилт | - | 2. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт дүрэм журмын дагуу баталгаажсан байна. | 1. Өмч эзэмшүүлэх 2021 оны гэрээг 95%-н дүнтэй дүгнүүлэв.<br>2. Актлах эд хөрөнгийн жагсаалт гарган, байгууллагын өмч хамгаалах коммисоор хэлэлцүүлэн гарсан шийдвэрийг ТӨБГЗ-т албан тоотоор хүргүүлэв.<br>3. 2022 оны үндсэн хөрөнгийн улсын тооллогыг хийж тогтоосон хугацаанд тайлагнан баталгаажуулав. | 90 |
| | | - | Өр авлага буурсан байдал | - | Түрээсийн өр авлага, алдагдлыг бууруулсан байна. | 1. ТӨБЗГ болон сангийн яаманд 2022 оны эхний хагас жилийн өрийн судалгаа гаргаж өгсөн.<br>2. 2021 оны аудитын зөвлөмжөөр ТӨБЗГ-т өгөх 70,2 сая төгрөгийн өглөгийн өр төлбөрийг данснаас хасуулсан.<br>3. 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөнд нийт авлагыг 20.0 сая төгрөгөөр, богино хугацаат өглөгийг 151.4 сая төгрөгөөр тус тус бууруулахаар төлөвлөсөн. Шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа 18 байгууллага, иргэний 63.9 сая төгрөгийг авлагыг бүрэн шийдвэрлэж дуусгахаар шүүхийн процесс үргэлжилж байна.<br>4. Байгууллагын газрын гэрчилгээг дахин баталгаажуулж, газар эзэмшилтэй холбоотой 86.0 сая төгрөгийн өр нэхэмжлэгдсэнийг хүчингүй болгов. | 90 |
| | | - | Түрээсийн орлого | - | Танхим түрээсийн орлогыг нэмэгдүүлсэн байна. /211,302,303/ | Байгууллагын танхим ашиглалтыг сайжруулах зорилгоор нийт 95 байгууллагын 474 цагийн түрээсээр 63,948,000₮ төгрөгийн орлого оруулсан бөгөөд өмнөх онтой харьцуулахад 4.7 дахин өссөн байна. | 100 |
| 7.3.3. | Цэвэрлэгээ үйлчилгээ, дэд бүтцийн ашиглалт үйлчилгээг сайжруулах | - | Цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал хийгдсэн байдал | - | Цэвэрлэгээ үйлчилгээ болон ариутгал тогтмол хийгдэж аятайхан ажиллах орчин бүрдсэн байна. | 1. Нийт 350 удаагийн их цэвэрлэгээг өрөө танхим болон нийтийн эзэмшлийн талбайд хийж, хог хаягдлыг товлосон хугацаанд ачуулж, байрны цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцан ажиллалаа. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Танхим түрээс болон үйл ажиллагаатай холбоотойгоор сандал, ширээг зөөж, байрлуулах ажлыг тогтмол гүйцэтгэж ажиллав. /Танхим түрээс, МТИШ, БМДИ сургалт, Бусад сургалт, Инновацийн 7 хоног, инкубаторын элсэлт төгсөлт, үнэлгээ, байгууллагын дотоод сургалт, уулзалт арга хэмжээ г.м/<br>3. Складны нэг өрөөг бүрэн суллаж эд, хогшлыг дээврийн хөндийд хураах, засвар өмнөх болон дараах цэвэрлэгээ хийх, дрож хулдаас дэвсэх ажлыг гүйцэтгэсэн.<br>4. Цахилгаан шитийн хэсэгт гэрэлтүүлэг хийлгэх, хог, хаягдлыг цэвэрлүүлэх, засварын ажил эхлэхэд талбайг бэлтгэв.<br>5. 3-р давхрын Гарден рүү элс зөөж талбайн гадаргууг тэгшлэх, 1-р давхрын болон гадна талбайн ногоон байгууламжийн зэрлэг зулгааж усалж, арчлах, аваарын шатанд бүрэн цэвэрлэгээ хийх зэрэг ажлыг хийж гүйцэтгэв.<br>6. СБД-ийн тохижилт, үйлчилгээний хэлтсээс ирүүлсэн албан даалгаврын хүрээнд байгууллагын эргэн тойрон дахь 50м талбайд их цэвэрлэгээ зохион байгуулж, тайланг холбогдох байгууллагад хүргүүлэв. | |
| | | - | -Шугамын шинэчлэлт, тохируулга<br>-Үзлэг үйлчилгээний тоо | - | Дулаан хангамжийн шугам хоолойн засварын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:<br>1. Гарашийн халаалтын систем шинэчлэгдсэн байна.<br>2. Ус хангамжийн систем шинэчлэгдсэн байна.<br>3. Ариутгах татуургын систем шинэчлэгдсэн байна. | 1. Зохих журмын дагуу тендер зарлагдсан боловч ажил гүйцэтгэх компанийн санал ирээгүй бөгөөд бараа материалын үнийн өсөлттэй холбоотойгоор дахин зарлах боломжгүй болж, энэ ажил зогссон.<br>2. Дулаан хангамжийн шугам хоолойн хэвийн ажиллагаа хангагдаж байгаа эсэхэд хяналт тавьж өдөр тутмын засвар үйлчилгээний бүртгэл тогтмол хөтөлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар угаалтуур болон АЦӨ-ний бөглөрлийг 91 удаа, засвар үйлчилгээний ажил 154 удаа хийж гүйцэтгэсэн байна. | 30 |
| | | -<br>- | Цахилгааны хуваарилах байгууламж шинэчлэгдсэн байдал<br>Үзлэг, үйлчилгээний тоо | -<br>- | Цахилгааны аудитын дүгнэлтийн дагуу цахилгаан байгууламжийн ашиглалт аюулгүй ажиллагааг сайжруулахад чиглэгдсэн ажлууд хийгдсэн байна. /0.4 кВ-ын тэжээлийн кабелийн гэмтэл засварлах, 0.4 кВ-ын хувиарлах байгууламж солих г.м/ | МТҮП-ын захирлын 07 сарын 27-ны 1а-44 тоот тушаалын дагуу Цахилгааны тоног төхөөрөмжийг шинэчлэх засварын ажлыг гүйцэтгэгч компаниас зохин журмын дагуу хүлээж авсан.<br>1. Үзлэг, үйлчилгээний ажил 65 удаа, тог залгалт 1 удаа, пускателийн доголдол засварлах ажил 8 удаа, ерөнхий шитний шалгалт 1 удаа гүйцэтгэсэн бөгөөд шатаж муудсан 300 ламп сольсон.<br>2. Гадна талбайд цахилгааны утас татах, анонсын 2 самбарын гэрэл засварлах ажил гүйцэтгэв.<br>3. Мэдээлэл хандалтын төвийн цахилгаан монтажны ажилд гүйцэтгэгч компанитай хамтран ажилласан. | 100 |
| | | - | Үзлэг, үйлчилгээ, хяналт хийсэн байдал | - | Галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд "Галын аюулаас урьдчилан сэргийлэх цогц | 1. Галын эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд "Галын аюулаас урьдчилан сэргийлэх цогц систем" суурилуулах чиглэлээр ITCARE ХХК, Amarvision ХХК гэсэн хоёр компаниас үнийн судалгаа | 0 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | систем" суурилуулсан байна. | хийлгэж ирэх оны зорилтот түвшинд тусгуулав.<br>2. Галын хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг шалган, нийт 33 галын хор цэнэглүүлж бүрэн бүтэн болгов.<br>3. Сар болгоны 25-нд галын хэрэглэлийн бүрэн бүтэн байдлыг холбогдох хүмүүсийн зааж зөвлөснөөр шалгаж бүртгүүлж байна. | |
| | | - | Үзлэг, үйлчилгээ, хяналт хийсэн байдал | - | Ковид 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | 1. Ковид-19 цар тахлын эрсдэлээс сэргийлэх зорилгоор 2022 оны 1-7 дугаар саруудад оффист 1,3,5 өдрүүдэд халдваргүйтгэл, ариутгал хийж байна. Мөн өглөө болгон кварцын гэрэл асааж халдваргүйтгэл хийж байна. Инкубатор компаниудын өрөөнд 2,4 өдрүүдэд ариутгал хийж байв.<br>2. Олныг хамарсан үйл ажиллагаануудад халдвар хамгаалалтын дэглэм сахиулан гар ариутгагч, халуун хэмжигч зэргийг тогтмол байрлуулж байна. | 100 |
| **Зорилт 7. 4** Дотоод хяналт, архив албан хэрэг хөтлөлт, ERP системийн ашиглалт үйл ажиллагаа | | | | | | | |
| 7.4.1 | Ажил дүгнэх журмыг хэрэгжүүлэх | - | Ажил дүгнэх журмын хэрэгжилтийн байдал | - | Ажил дүгнэх журмын дагуу холбогдох үнэлгээ, тайлан мэдээллийг боловсруулж, санал зөвлөмж танилцуулсан байна. | 1. Сар бүр ажилчдын үнэлгээ, байгууллагын нэгдсэн тайланг гарган бүх ажилчдад танилцуулан, зөвлөмж өгч ажилласан бөгөөд жилийн эцсийн дундаж үнэлгээгээр хэлтэс тус бүрээс хамгийн өндөр оноотой байгаа ажилтан, албан хаагчдыг холбогдох журмын дагуу урамшуулах санал оруулав.<br>2. Хэлтсүүдийн сарын төлөвлөсөн ажлын биелэлт дунджаар 83 хувьтай байлаа. Сар бүр тухайн сарын ажлын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, бүх нийтийн хурлаар санал, зөвлөмжийг танилцуулж ажиллалаа. | 90 |
| 7.4.2 | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, тушаал шийдвэрийн баталгаажуулалт | - | Боловсруулсан гэрээний тоо | - | Байгууллагын албан хэрэг хөтлөлт, тушаал шийдвэрийн баталгаажуулалт стандартын дагуу хийгдсэн байна. | 2022 оны жилийн эцсийн байдлаар Үйл ажиллагааны тушаал- 71, Боловсон хүчний тушаал-91, Ирсэн бичиг-214, Явсан бичиг -593 байна. | 70 |
| 7.4.3 | Архивын үйл ажиллагааг дүрэм журмын дагуу эрхлэн явуулах | - | Архивын баримт бичиг бүрдүүлэлтийн байдал | - | Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу холбогдох материалууд цаасан болон цахим хэлбэрээр архивлагдсан байна. | 1. ББНШК-ын хурлыг 1 удаа зохион байгуулж, архивын 2022 оны хөтлөх нэрийн жагсаалтын товъёгийг 40 төрлийн 58 баримтын жагсаалтаар гаргав. 1 дүгээр улиралд 38 ширхэг архивын баримтыг хүлээн авав.<br>2 .Үндэсний төв архивын газраас ирсэн шаардлагын дагуу МТҮП-ын архивын хадгаламжийн 522 нэгжид 5 удаагийн давтамжаар засвар хийж товъёг хүргүүлсэн.<br>Байгууллагын хэмжээнд ажилтан, албан хаагчдад 84 ш хадгаламжийн нэгжээр үйлчилсэн байна.<br>Байгууллагын цахим архивыг гүүгл драйв ашиглан 9 төрлийн 967 ширхэг файлаар арвижуулав. | 70 |
| 7.4.4 | ERP системийн ашиглалт үйл ажиллагааны хэвийн ажиллагааг хангах | - | Системийн ашиглалт, хөтлөлтийн байдал | - | Динамик систем болон Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн системийн ашиглалтыг одоо | Динамик систем рүү 7 хоног бүр ажилтан албан хаагчдын ажлын цагийг мэдээг шивж оруулж байна. Мөн шинээр ажилтан ажилд ороход шинээр мэдээллийн талбар үүсгэх, гарахад мэдээллийг нэмэх болон программаас хувийн мэдээлэл, албаны мэйл хаяг устгах ажлыг цаг тухай бүрд нь хийж байна. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгаагаас 10%-иар нэмэгдүүлсэн байна. | | |
| **Зорилт 7.5** Техник, програм хангамжийн хэвийн ажиллагааг хангах | | | | | | | |
| 7.5.1 | Байгууллагын цахим хуудасны найдвартай хэвийн ажиллагааг хангах | - | Үзлэг, үйлчилгээ, хяналт хийсэн байдал | - | Цахим хуудасны техникийн найдвартай хэвийн ажиллагаа хангагдаж, доголдолгүй ажиллах бололцоог бүрдүүлсэн байна. | 1. Цахим хуудас болон бусад тоног төхөөрөмжтэй холбоо бүхий 2.2 гб хэмжээтэй файл /email, subdomain, server нууц үг болон нэр,Камер бүртгэл, Тоног төхөөрөмжийн бүртгэл, Вэбсайтын backup/ "rar" болгон Программ хангамжийн инженерт хүлээлгэн өгөв.<br>2. Вебсерверт 2 удаа, байгууллагын цахим хуудасны мэйл явуулдаг хэсэгт 1 удаа алдаа гарсныг илрүүлэн засварлаж хэвийн ажиллагаанд оруулав.<br>3. И-мейл болон Динамикт 11 ажилтны шинэ бүртгэл үүсгэж, 17 ажилтны нууц үг, И-мейлийг сэргээв.<br>4. Вэбсайт PDF файл уншихгүй байсныг засварлаж хэвийн болгосон.<br>5. Мэдээлэл хандалтын төвийн subdomain нэмж ажиллагаанд оруулав. | 100 |
| 7.5.2 | Сүлжээ, холбооны тоног төхөөрөмжийн найдвартай хэвийн ажиллагааг хангах . | - | Үзлэг, үйлчилгээ, хяналт хийсэн байдал | - | Сүлжээ, холбооны хэвийн ажиллагааг хангаж доголдолгүй ажиллах бололцоог бүрдүүлсэн байна. | 1. МТҮП-н байранд интернэт сүлжээ удаа дараалан тасалдсаныг цаг тухайд нь засварлав. 7 өрөөнд шинэ порт нэмж сүлжээ оруулав.<br>2. "Монголын Инновацийн 7 хоног" арга хэмжээ МТҮПаркад зохион байгуулагдах болсонтой холбогдуулан 05.16-25 ны өдрүүдэд Мобинэт ХХК-ийн утасгүй интернэтийг хязгааргүй хурдтайгаар нэвтрүүлж интернэтээр хангаж ажилласан.<br>3. Ситинет-тэй гэрээг цуцалж, Мобинеттэй гэрээ байгуулан холболтын ажлыг мобикомын инженертэй хамтран гүйцэтгэв. Ситинетийн эзэмшлийн 3ш свичийг хүлээлгэн өгч, 211-ийн 2 свич, Оффисын свич, 4-р давхрын свичүүдийг шинэчлэв.<br>4. Серверийн өрөөний File server-ийг засварлан дотоод сүлжээнд ашиглаж байна. 2023 онд cloud байдлаар шийдэхээр төлөвлөөд байна.<br>5. Сургалт, шалгалт, танхим түрээс бусад үйл ажиллагаануудад сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хангаж ажиллав.<br>6. Байгууллагын дотуур холбооны 2 телефон утсыг засаж ашиглалтад оруулав.<br>7. Мэдээлэл хандалтын төвд сүлжээ оруулав. Мөн техникийн тусламж дэмжлэг үзүүлэв. | 90 |
| 7.5.3 | Техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн хэвийн ажиллагааг ханган ажиллах, шинэчлэх, засварлах | - | Үзлэг, үйлчилгээ, хяналт хийсэн байдал | - | Шаардлагатай тоног төхөөрөмжийг шинэчилсэн байна. | 1. Сургалт, шалгалт, танхим түрээс болон бусад үйл ажиллагааны хүрээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжийн найдвартай хэвийн ажиллагааг хангаж ажиллав.<br>2. Худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгаа гаргасан. Үүнд: /5ш камер, Сүлжээний call tester, Утастай микрафон 2ш/<br>3. Хоёр ажилтан, албан хаагчид үйлдлийн систем шинээр суулгах, Оффис принтерийн IP тохируулга хийв. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4. 27 инчийн All in One 3 ш системийн гэмтэл гарсныг шинээр үйлдлийн систем суулган засварлаж, 20ш компьютерт router болон switch тохируулга хийж сүлжээнд холбон сургалтад ашиглахад бэлэн болгов. | |
| 7.5.4. | Цахим сургалтын системийг нэвтрүүлэх | - | Бэлтгэл хангагдсан байдал | - | Байгууллагаас зохион байгуулж буй 2 үндсэн сургалтыг цахим хичээл болгох бэлтгэл ажиллагааг хангасан байна. | Go smart компанийн Dynamic ERP платформд сургалтын контентуудыг 2023 онд туршилтаар нэвтрүүлэх бэлтгэл хангагдав. | 50 |
| 7.5.5. | Мэдээллийн санг автоматжуулах | - | Туршилт хийгдсэн байдал | - | Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүсгэсэн мэдээллийн санг автоматжуулах ажлыг эхлүүлэн, турших үзсэн байна. | Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд үүссэн мэдээллийн санг автоматжуулахаар оффис 365, Динамик ERP-ийг харьцуулан автоматжуулалтын туршилтын ажлыг эхлүүлээд байна. Гүйцэтгэл 40%. | 30 |
| **Бусад ажил** | | | | | | | |
| **Зорилт 8.1** Цаг үеийн бусад ажлууд | | | | | | | |
| 8.1.1 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар | - | Тайлан мэдээлэл, цаг хугацаандаа үнэн зөв хүрсэн байдал | - | ЦХХХЯ-аас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажилласан байна. | 1. ЦХХХЯ-ны өгсөн үүрэг даалгаврын дагуу E mongolia академи рүү байгууллагын план зургийг бүрэн эхээр нь болон хэсэгчлэн, Өргөө 2 кино театрын зургуудыг шаардлагын дагуу бэлтгэн хүргүүлэв.<br>2. 2023-2025 зорилтын санал боловсруулж хүргүүлэв.<br>3. Байгууллагын хувьчлалтай холбоотой танилцуулга ппд-д бэлтгэн хүргүүлэв.<br>4. ЦХХХЯ-с "тэрбум мод" үндэсний хөдөлгөөний нийслэл дэх мод тарих үйл ажиллагаанд байгууллагын 3 ажилтныг оролцуулсан.<br>5. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн тайланг бэлтгэн хүргүүлэв.<br>6. Засгийн газрын тэтгэлгээр болон Боловсролын зээлийн сангийн зээлээр суралцсан албан хаагчдын мэдээллийг хүргүүлсэн.<br>7. Яамдын спорт тэмжээнд байгууллагаас 15 албан хаагч хөгжөөн дэмжигчээр оролцов.<br>8. Байгууллагын эрсдлийн үнэлгээг шаардлагын дагуу боловсруулан хүргүүлэв.<br>9. 2022 оны эхний өргөдөл гомдлын тайлан мэдээг 10 дугаар сарын байдлаар нэгтгэн бэлтгэн хүргүүлсэн.<br>10. Байгууллагын байрны талбайн хэмжээ болон батлагдсан орон тооны мэдээллийг хүргүүлсэн.<br>Байгууллагын 1-р давхарт Мэдээлэл хандалтын төв /IAC/ байгуулахтай холбоотой дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:<br>1. МХТ-ийн шаардлагын дагуу 1-р давхрын план зураг болон талбайн хэмжилт, өрөө танхимын зураг, видео зэрэг материал бэлтгэн ЦХХХЯ, БНСУ-ын холбогдох байгууллагад хүргүүлэх<br>2. ЦХХХЯ, МТҮПарк, БНСУ-ын төлөөлөл, И-Монгол академи зэрэг байгууллагуудын ажлын хэсгийн хуралд 3 удаа оролцож мэдээлэл солилцох<br>3. ЦХХХЯ болон Солонгос талын төлөөлөгчдийг байгууллага дээр | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүлээн авч, мэдээлэл солилцох, 1-р давхрын талбайтай танилцах бололцоогоор хангах<br>4. Байгууллагын байранд байрладаг аж ахуйн нэгжүүдийг үйл ажиллагааны чиглэл, товч танилцуулга бүхий жагсаалт гаргаж өгөх<br>5. Байгууллагын Лого, гадна болон дотор фото зургийг илгээх | |
| | | - | Тайлан мэдээлэл, цаг хугацаандаа үнэн зөв хүрсэн байдал | - | ЗГХЭГ, ТӨБЗГ болон бусад төрийн байгууллагуудаас өгсөн үүрэг, чиглэлийн биелэлтийг хангаж ажилласан байна. | 1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А-1/532 тоот албан бичгийн загварын дагуу 04 дүгээр сарын 11-ний өдөр 2021 оны аудитын санхүүгийн тайланг нэгтгэн албан тоотоор хүргүүлсэн.<br>2. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн А-1/652 тоот бичгийн дагуу сүүлийн 3 жилийн аудитын тайланг хавсралт загварын дагуу гүйцэтгэн хүргүүлсэн.<br>3. 2022 оны Захирлын контрактын гэрээний биелэлтийн материал бэлтгэн ТӨБЗГ-т хүргүүлэв.<br>4. ЗГХЭГ-т 1 судалгаа ТӨБЗГ-т 1 судалгаа болон 7 төрлийн тайлан мэдээ гаргаж хүргүүлэв.<br>5. СБД-н НДХ-с шаардсаны дагуу сантехникийн инженер Д.Энхбатын 2002-2004 оны цалинг архиваас шалган түүж залруулга тайлан гаргаж өгөв.<br>6. Үндэсний аудитын шинэ программд 2021 оны мэдээлэл оруулсан.<br>7. ТӨБЗГ болон ЦХХХЯ-с ирүүлсэн автомашины дэлгэрэнгүй судалгаа хийж хүргүүлсэн. | 100 |
| | | - | Тайлан мэдээлэл, цаг хугацаандаа үнэн зөв хүрсэн байдал | - | Байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг хангаж ажилласан байна. | 1. Гүйцэтгэх удирдлагын өгсөн үүрэг даалгаврын хүрээнд МТҮП-ын зөвлөх Жакоб Ковакcд хүний нөөцийн мэргэжилтэн Монгол хэлний хичээлийг 7 хоногийн Даваа, Мягмар, Лхагва гаригуудад 9:00-10:30 цагийн хооронд зааж байна. /3-5 сард<br>2. Байгууллагын шинэчлэгдсэн дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэв.<br>3. Үзмон ХХК-р газрын төлөв байдал,чанарын хянан баталгаажуулалт хийлгэв. | 100 |
| | | | | | | "Тогтвортой хөгжлийн зорилт" нээлттэй хаалганы өдөрлөгт ШУА-ийн 3 хүрээлэнгийн 10 нэр төрлийн инновацийн бүтээгдэхүүнээр оролцов. | |
| 8.1.2 | Ажлын хэсэг болон бусад | - | | - | Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс | 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 1а-02 дугаар тушаалаар Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс байгуулагдан ажлын хэсэг 1 удаа хуралдаж байгууллагын вэб сайт болон өдөр тутмын сонинд зарлал гаргасан. Үүний дагуу байгууллагын байрны өрөө танхимуудыг түрээслэх хүсэлтийг холбогдох журмын дагуу хүлээн авсан. | 90 |
| | | - | | - | Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комисс | 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1а-05 тушаалаар байгууллагын баримт бичиг нягтлан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шалгах комисс байгуулагдан архивд хүлээлгэж өгөх баримт бичгийн бүрдлийг стандартын дагуу үйлдсэн эсэхийг нягталж шалгасан. | |
| | | - | | - | "Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, агуулга боловсруулах" ажлын хэсэг | ЦХХХЯ-аас гаргасан "Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг хөгжүүлэх хөтөлбөр, агуулга боловсруулах" ажлын хэсгээс гаргасан сургалтын хөтөлбөрт 6 санал оруулав. | 100 |
| | | - | | - | Жендэрийн үндэсний хорооны ажлын хэсэг | 1. 2022 оны 05 дугаар сарын 20-нд ЦХХХЯ, Жендерийн үндэсний хорооны ажлын хэсэгт ажиллаж, хуралд оролцож, Жендерийн үндэсний хорооны тавьсан шаардлагаар тайлан мэдээ явуулсан.<br>2. ЦХХХЯ-ны хэрэгжүүлж буй Жендерийн үндэсний хорооны бодлого боловсруулах зөвлөлд байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй иргэний мэдээ тайланг хүргүүлсэн.<br>3. Засгийн газар, Боловсролын зээлийн сан болон хоёр улсын хоорондын гэрээ хэлэлцээрийн тэтгэлгээр гадаад дотоодод суралцсан ажилтан, албан хаагчдын мэдээллийг илгээсэн. | 90 |
| | | - | | - | Тендерийн үнэлгээний хорооны үйл ажиллагааг хэрэгжүүлж ажилласан байна.<br>1. Ажлын хэсгийн хурал<br>2. Тендерийн зар мэдээлэл нийтлэх<br>3. Тендерт ирүүлсэн материалыг ажлын хэсгээр шалгаж, дүгнэлт гаргах<br>4. Гэрээ байгуулах | 2022 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн захирлын 1а-14 тоот тушаалаар нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй үнэлгээний хороо байгуулагдан нийт 5 тендер шалгаруулалт явуулсан.<br>1.Цахилгаан шатны нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа зарлан зохион байгуулснаас нэг сонгон шалгаруулалтад гомдол гаран шалгагдан буцаагдаж, 2 удаагийн зараар оролцогч ирээгүй.<br>2.Барилгын их засварын нээлттэй тендер шалгаруулалтыг 3 удаа явуулсан боловч үнийн санал хэт бага шалтгаанаар оролцогч ирээгүй.<br>3.ITHub-2 тохижилтын тендер шалгаруулалтыг 1 удаа зохион байгуулж оролцогч ирээгүй энэ ажлыг хийхгүй байхаар тохирсон тул дахин зарлаагүй.<br>4.Гражийн дээврийн засварын ажлын тендер шалгаруулалтыг 3 удаа явуулсан боловч оролцогч ирээгүй.<br>5.Цахилгааны материал нийлүүлэх тендер шалгаруулалтыг 3 удаа явуулсан. Эхний сонгон шалгаруулалтаар шаардлага хангасан оролцогч ирээгүй. Хоёр дах сонгон шалгаруулалтаар Цэгц шийдэл ХХК болон Стандарт нетворк ХХК-ууд материал ирүүлж шалгаруулалт хийн Стандарт нетворк ХХК-тай гэрээ байгуулан ажлыг 100% хийж гүйцэтгэсэн. | 100 |
| | | - | | - | БНСУ-ын NIA байгууллагын буцалтгүй тусламжаар байгуулагдаж буй IAC төслийн хүрээнд хийгдсэн засварын ажил, тоног төхөөрөмж | Төслийн хүрээнд хийгдэх засварын ажил 2022.10.13-нд эхэлсэн бөгөөд Ажлын хэсгийг 2022.11.25-ны 10-67 тоот тушаалаар 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдсан. Ажлын хэсэг засварын ажил болон тоног төхөөрөмж хүлээн авч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хүлээн авах, нээлт зохион байгуулах ажлын хэсэг | суурилуулахад хяналт тавьж, 12-р сарын 15-нд нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулсан. Төвийн нээлтийн ёслолын ажиллагаанд БНСУ-ын Үндэсний Мэдээллийн Нийгэмлэгийн Агентлагийн дэд захирал Пак Вон Жэй, БНСУ-ын Үндэсний Мэдээллийн Нийгэмлэгийн Агентлагийн хэлтсийн дарга Хун Мюн Ха, БНСУ-ын Үндэсний Мэдээллийн Нийгэмлэгийн Агентлагийн ахлах менежер Жинсү Им нар хүрэлцэн ирж оролцов. Мөн нээлтийн үеэр Монгол, Солонгос талуудын уулзалт, NIA болон МТҮП хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаанууд давхар зохион байгуулагдсан бөгөөд 80 гаруй хүн хамрагдсан байна. | |
| **Биелэлтийн дундаж** | | | | | | | **97.5** |

66.24

*Төлөвлөгөөг хянасан:* ***Төсвийн Ерөнхийлөн захирагч***

ШХХХ Сайд .................... ....................... ..............................

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

*(огноо)* ..............................

Тэмдэг

*Төлөвлөгөө тайлагнасан:* ***Төсвийн Шууд захирагч***

Захирал ...................... ...................... Ж.Ногоонсэрэн

*(албан тушаал)* *(гарын үсэг)*

2023.1.31 *(огноо)*

Тэмдэг

ТЕХНОЛОГИЙН ... MONGOLIAN ... ТӨААТҮГ